

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.04.10, ДАВАА ~ №065 (611)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

УИХ-ын зарим гишүүн Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилттэй танилцлаа.
Сангийн сайд Б.Чойжилсүрэн нийгмийн даатгалын шимтгэлийг огцом нэмэхгүй гэв.
АН-ын гишүүн Д.Дорлигжав Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээ мэдэгдлээ.
Оффшор бүсэд данс эзэмшихийг хориглох хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлэв.
АН 27 жилийн ойгоо тэмдэглэж, шинэчлэлийн ажлаа эрчимтэй эхлүүлснээ тодотгов.

ЭДИЙН ЗАСАГ

Монголын хөрөнгийн биржийн индекс баасан гарагт 841.28 нэгж болж, 1.23 хувиар буурав.
Нүүрсний экспорт нэмэгдсэнээр урсгал дансны алдагдал ДНБ-ий 2.1 хувьд хүрч буурахаар байна.
Төв банкны нэг долоо хоногтой үнэт цаасны үлдэгдэл нэг их наяд төгрөгт хүрэв.
БНХАУ-ын эдийн засгийн өсөлт энэ онд 6.5 хувь, ирэх онд 6.2 хувиар өсөх төлөвтэй байна.
“Amazon” компани ирэх онд шинээр 30 мянган цагийн ажилтан авахаар төлөвлөжээ.

НИЙГЭМ

ДЭМБ сэтгэл гутралын асуудалд анхаарал хандуулахыг улс орнуудад уриаллаа.
Туул голын хамгаалалтын бүсээс дөрвөн байгууллага хайрга олборлож байжээ.
ГССҮТ нурууны гэмтэл засах шинэ технологи нэвтрүүлээ.
Нийслэлийн ЗДТГ-т таван чиглэлээр аудитын шалгалт оруулахаар болжээ.
Гадаадын иргэн, харьяатын газраас гаднын иргэдийн визний хариуг мессежээр илгээнэ.

ДЭЛХИЙ

АНУ Хойд Солонгосын эрэг рүү тэнгисийн цэргийн хөлгүүдэд илгээсэн байна.
Москвад зорчигч тээврийн галт тэрэг мөргөлдсөнөөс 31 хүн шархдав.
Норвегийн нийслэл Осло хотын метроны үүдэнд тэсрэх бодис илэрчээ.
Шведийн Стокгольмд болсон халдлагад Узбекистаны иргэнийг сэжиглэж байна.
Хятад улс сүүлийн 10 жилд дэлхийн хамгийн том алт үйлдвэрлэгчээр тодорлоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.04.10



4° -4°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЖИГҮЙ МЭДЭЭЛИЙГ 7 ДУГААР НУУРГУУЖ ҮНИШНА УУ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Төгрөгийн ханш инфляцийг тодорхойлно



Инфляци хэдий өсөх ч мөнгөний бодлогын зорилтот түвшнээс бага байх төлөвтэй байна. Гэхдээ төгрөгийн ханш тогтворгүй байвал инфляци өсөлтийн зүг чиглэх нь. ►11

Б.Ганбаяр /ЗГМ©

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ҮЗЭСГЭЛЭНГ “МИАТ” ӨНГӨЛЛӨӨ



“Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2017” сэдэвт өдөрлөгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас дөрөвдүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд “Тэнгэр плаза” төвд зохион байгууллаа.

Мэдээллээ тэр болгон олон нийтэд тайлагнаад байдаггүй Эрдэнэт, МИАТ, УБТС, Эрдэнэс Тавантолгой, ДЦС, УБЦТС зэрэг манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компаниуд үйл ажиллагаагаа нээлттэй сурталчилан импортыг орлох бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний үйлдвэрүүдийг хэрхэн дэмжиж худалдан авалт хийдэг талаараа, хүний нөөцийн бодлого, байгууллагын менежмент ашиг орлого болон

нийгмийн хариуцлагын чиглэлээр ямар ажлууд хийдэг талаар олон нийтэд тайлагнасан юм.

Үзэсгэлэнг үзэж сонирхсон хэн бүхэн хэрэгтэй мэдээллээ төрийн өмчит компаниудаас авч чадлаа хэмээн сэтгэл хангалуун байсан. Өдөрлөгт оролцож буй төрийн өмчит компаниуд бүгд үйл ажиллагааны онцлогийг илтгэсэн байдлаар сурталчилгааг явуулж байсны дотор Монгол Улсын Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК-ийн агаарын хөлгийн үйлчлэгч бүсгүйчүүд онгоцны энгийн болон бизнес ангиллын зорчигчдод олгодог хоол хүнсний олон нийтэд амтлуулж байсан нь иргэдийн сонирхлыг ихээхэн татаж байсан юм.



Мөн энэ үеэр хүний нөөцийн хэлтсээс нь агаарын хөлгийн үйлчлэгч болох хүсэлтэй охид бүсгүйчүүдэд мэдээлэл өгч байсан бол хангамж үйлчилгээний хэлтсээс бараа ажил үйлчилгээ худалдан авах, тендертэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг сонирхсон хүн бүрт тайлбарлан өгч уг үзэсгэлэнд онцгой ач холбогдол өгч оролцож байгаа нь илт байлаа.

►5

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Марихуанатай дайтсан 80 жил

О.Мишээл
ЗГМ

хар тамхитай АНУ нүүр тулж, тэмцсэн түүх сонирхолтой.

Сархадын дэлгүүрийн эзэд байх учиртай хүмүүсийг цуутай гангстерууд болгосон алдаагаа АНУ 1933 онд зассан. Холбооны Засгийн газар согтууруулах ундааны эсрэг олон жилийн дайнаа зогсоож, спиртийн ундаа үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон “хуурай” хуулийг цуцалснаар америкчууд дахин виски уух эрхтэй болов.

Гэвч архийг устгах тэмцэлд ялагдсан АНУ-ыг шинэ дайн хүлээж байлаа. Энэ бол өдгөө АНУ-аас хальж, дэлхий нийтийн толгойн өвчин болж, тэрч бүү хэл монгол залуусын дунд “моод” болоод буй хар тамхи юм. Өдгөө бид үр хойчийнхоо төлөө анхаарахаас аргагүй болоод буй

Архитай тэмцэх холбооны комиссарын орлогч Харри Анслингерийг Сангийн яамны харьяа Холбооны мансууруулах бодистой тэмцэх товчооны тэргүүнээр томиллоо. Чухам энэ хүн орчин үеийн ертөнцөд хамгийн удаан үргэлжилж буй “өвс”-ний эсрэг дайныг санаачлагч нь. Олсны ургамал мансууруулах нөлөөтэйг хүн төрөлхтөн эртнээс мэднэ. Каннабисын цэвэршүүлсэн ханд болох гашиш нь онц хүчтэй мансууруулах үйлчилгээтэй. Гэхдээ үйлдвэрлэлийн зориулалтаар өргөн ашигладаг олсны ургамлын тариалан АНУ төдийгүй дэлхийн бусад улсад ч түгээмэл.

►3

ЗГМ: СЭДЭВ

Мэдрэмжгүй мэргэжил сонголт

Манайд 4000

орчим мэргэжил бий

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Манай улс зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэж чаддаг, эсэх нь бүрхэг хэвээр. Их, дээд сургууль төгссөн ажилгүй залуус “лааз өшиглөгчид”-ийн эгнээнд шилжсээр байгаа нь нууц биш. Зарим нэг төрийн бус байгууллагаас эрэлттэй мэргэжлийн талаар судалгаа

►5

MSE ALL

841.28
1.23%

АЛТ

1253.80
0.18%

ЗЭС

5834.00
0.41%

10-ЧИНГИС БОНД

99.950
0.04%

5-ЧИНГИС БОНД

94.790
0.04%

АМ.ДОЛЛАР

2428.75

ЮАНЬ

352.03

РУБЛЬ

42.69

Улс төр

УЛСЫН ИХ ХУРАЛ

Зөвлөлдөх тогтоолын төслийг баталлаа

12 сэдвийн хүрээнд зөвлөлдөх санал асуулга явуулахаар тогтоолд тусгажээ

Б.Ганаа
ЗГМ



УИХ-ын чуулганы хуралдаанаар Зөвлөлдөх санал асуулга явуулах, Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа. Төсөлд Зөвлөлдөх санал асуулгыг энэ сарын 29, 30-нд Төрийн ордонд зохион байгуулах, санал асуулгын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлжээ тусгажээ. Мөн зөвлөлдөх санал асуулга явуулах эсвэл тусгажээ тусгажээ. Тухайлбал, Засгийн газрын бүрэлдэхүүнээ тогтоох, гишүүдийг томилох, чөлөөлөх эрхийг Ерөнхий сайдад олгох, Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс дээшгүй хувь нь УИХ-ын гишүүн байж болохоор хязгаарлах, Засгийн газрын бүтцийг Үндсэн хуулиар тогтоож, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах зорилгоор яамдын нэрийг хуульд зааж өгөх юм байна.

эрхийн хугацаа зургаан жил байх, улируулан сонгохгүйгээр УИХ-ын өргөтгөсөн хуралдаанаас сонгодог болохоор өөрчлөх аж. Түүнчлэн Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн зарим бүрэн эрхийг өөрчилж, хууль санаачлах, Засгийн газарт чиглэл өгсөн зарлиг гаргах эрхийг хасах зэрэг асуудлыг тусгажээ. Төрийн албаны зөвлөлийг улс төрөөс хараат бус, Үндсэн хуулийн эрх мэдлийн байгууллага болгох, төрийн жинхэнэ албыг мэргэшсэн, тогтвортой, шатлан дэвших зарчимд шилжүүлэх, Үндсэн хуульд бэхжүүлэх, баг, хороо, тосгоны Засаг даргыг улсын чанартай хот болон сум, дүүргийн Засаг дарга шууд

томилдог болох асуудлаар санал асуулга явуулахаар заажээ. Түүнчлэн төрийн хариуцлага, сахилга, шударга ёсыг бэхжүүлэх, хууль хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах асуудлын хүрээнд улс төрөөс ангид төрийн хариуцлага, сахилгыг дээшлүүлэх, авлигатай тэмцэх бодлогын хэрэгжилтийг хангах нь санал асуулгын нэг гол сэдэв байх аж. Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 6.1.1 дэх хэсэгт Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.3.3-г заасан асуудлыг УИХ хэлэлцэн шийдвэрлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлох үүднээс зөвлөлдөх санал асуулгыг

явуулахаар заажээ. Мөн Зөвлөлдөх санал асуулгаар санал авах ажлыг статистикийн байгууллага гүйцэтгэх хуулийн заалттай. Энэхүү санал асуулга хоёр шаттай байх юм байна. Санал асуулгын эхний шатанд Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн оролцох эрхтэй бөгөөд тоог нь зөвлөлдөх санал асуулгын сэдэв, хамрах хүрээг харгалзан Үндэсний статистикийн хорооноос баталсан аргачлалын дагуу Зөвлөлдөх зөвлөл тогтоох юм байна. Ингэхдээ Зөвлөлдөх санал асуулгын нэг дэх шатанд оролцох иргэнийг энэ хуулийн 11.5-д заасан тоонд багтаан хамгийн сүүлийн удаа явагдсан УИХ болон аймаг, нийслэл,

сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар гаргасан сонгогчдын нэрийн жагсаалтаас тохиолдлын зарчмаар сонгож авахаар заажээ. Харин Зөвлөлдөх санал асуулгын хоёр дахь шатанд нэг дэх шатанд оролцсон иргэний 50-наас доошгүй хувийг оролцуулах юм байна. Түүнчлэн Зөвлөлдөх санал асуулгад оролцогч иргэн саналаа чөлөөтэй гаргахад хөндлөнгөөс нөлөөлөх, санал худалдан авахыг хуулиар хоригложээ. Оролцогчид Үндсэн хуульд зөвхөн нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд л асуудал яригдана, түүнээс цааш халих асуудал байхгүй гэдгийг УИХ-ын гишүүн Д.Лүн-дэжжанцан тодотгов. [ЗГМ]

ТОВЧХОН

» **ТӨСӨЛ**
УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлэв. Төсөлд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг 39000 гаруй албан тушаалтан оффшор бүсэд данс эзэмшихийг хуулиар хориглохоор тусгасан юм.

» **АЖЛЫН ХЭСЭГ**
УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны тогтоолоор байгуулсан Ажлын хэсгийнхэн Монгол-Германы ашигт малтмалын технологийн их сургууль дээр ажиллаж, Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилтэй танилцав. Энэ үеэр дэлхийн жишигт нийцсэн судалгааны их сургууль болгохын тулд олон төрлийн лаборатори байгуулж, оюутнуудыг өргөн мэдлэгтэй болгож дадлагажуулах шаардлагатай байгааг онцоллоо.

» **ТОО**
160
Сая ам.доллар. Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг Хамтын ажиллагааны стратегийн баримт бичигт үндэслэн шийдвэрлэдэг. Тэгвэл Засгийн газар 2017-2019 онд Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн 160 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг ашиглахаар төлөвлөж байна.

» **ПАРЛАМЕНТ**
УИХ-ын даргын дэргэдэх зөвлөл хуралдаж, энэ долоо хоногт чуулган, байнгын хороогоор хэлэлцэх асуудлыг баталжээ. Энэ долоо хоногт Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголыг үргэлжлүүлэн хэлэлцэх аж. Мөн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэнэ.

ЭШЛЭЛ



-Хэдийгээр УИХ-ын шийдвэр гарсан ч гэлээ Эрдэнэтийн 49 хувийг Монголын зэс корпорациас ийм болхи байдалаар шууд нийгэмчилж байгаа юм шиг авч болохгүй л дээ. Бид зорилго нь арга зөвтгөнө гэдэг коммунист арга барилаар биш хуулийн засаглал доор ажиллаж амьдардаг эрх зүйт төрийн тогтолцоог 25 жилийн өмнө сонгосон. Энэ нь манай улсын язгуур эрх ашиг гэдгийг мартаж болохгүй. Нөгөөтэйгүүр, компанийн төрд 100 хувь авлаа гээд сайн сайхан болчих итгэл найдвар байхгүй. Харин ч эрх мэдэлтнүүдийн идэж уух савны хэмжээ томорч байдгийг бид харж байна. “Эрдэнэт”-ийн олон дарга, захирлуудын цалин хангамж, шахааны талаар манай хэвлэл мэдээллийнхэн эрэн сурвалжилж гаргаж тавьж байгаа нь сайн хэрэг.

УИХ-ын гишүүн
Л.Болд

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» **OPED@ZASAG.CO**

Утас. 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

НАМУУД

Д.Дорлигжав Ерөнхийлөгчид нэр дэвшинэ гэдгээ мэдэгдлээ

Б.Тогтох
ЗГМ

Ирэх зургадугаар сарын 26-нд Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох долоо дахь удаагийн сонгууль болно. Сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдийн нэрсийг тавдугаар сард албан ёсоор зарлах юм. Тэгвэл үүнээс өмнө Ардчилсан нам

Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчээ сунгаагаар тодруулахаар болсон. Өнөөдрийн байдлаар Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг, хотын дарга асан Э.Бат-Үүл нар намын дотоод сунгаандаа өрсөлдөхө мэдэгддэг буй. Тэгвэл өнгөрсөн баасан гарагт Хууль зүйн сайд асан Д.Дорлигжав Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх нэр

дэвшигчийг тодруулах сунгаанд оролцох болсноо албан ёсоор зарлалаа. Тэрбээр “Улс төрийн нөхцөл, цаг үеийн ороо бусгаа байдал намайг ийм шийдвэр гаргахад нөлөөлсөн. Эдийн засгийн нөхцөл байдал, засаг төр, улс орны маань байж байгааг царайг харсан ч ерөөсөө ингээд гараа хумхиад суух хэрэггүй гэж шийдсэн юм. 1990 онд ардчилал, хүний эрхийг дэмжээд сэтгэлийн

дуудлагаар улс төрд хөл тавьж байсан бол сая бас л сэтгэлийн дуудлагаар шийдвэрээ гаргасан” гэлээ. Д.Дорлигжав нь Ардчилсан намын анхны даргаар ажиллаж байсан. Мөн Шадар сайд, Батлан хамгаалахын сайд, Хууль зүйн сайд, Улсын ерөнхий прокурорын албыг хашиж явсан билээ. [ЗГМ]

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Эх оронч, эрдэм мэдлэгтэй залуусыг дэмжих хуулийн төсөл

Гарааны бизнес эрхэлж байгаа залууст хөнгөлөлттэй зээл олгоно

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн талаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн газрын дарга Г.Батдоржтой ярилцлаа.



С.Батсайхан / ЗГМ

-Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг хаврын чуулганаар хэлэлцэнэ. Энэ хуулийг боловсруулах болсон шалтгаан юу вэ?

-Энэ хаврын чуулганаар нийт 34 асуудал хэлэлцэхийн 24 дүгээрт Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль орсон. УИХ болон Засгийн газрын шийдвэрээр Хүүхдийн төлөө үндэсний газрын бүтэц, үйл ажиллагааг өөрчилж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болгосон. Ингэснээр Монгол Улс өнгөрсөн 26 жилийн хугацаанд байгаагүй залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны нэгжтэй болсон гэсэн үг. Одоогоор залуучуудын дунд хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, боловсролын асуудал хамгийн их тулгамдаж байна. Эдгээрийг шийдвэрлэх, нөгөөтэйгүүр эх оронч, эрдэм мэдлэгтэй, өндөр

ур чадвартай залуучуудыг дэмжих, бэлтгэх үүднээс энэ хуулийн төслийг боловсруулсан. -Хуулийг баталчихвал залуучуудад ямар эрх зүйн таатай орчин бүрдэх вэ. Ялангуяа, хөдөлмөр эрхлэлт, боловсролын салбарт тэдэнд ямар боломж нээгдэх вэ?

-Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хэд хэдэн заалт орсон. Тухайлбал, их, дээд сургууль төгссөн буюу шинэ боловсон хүчин, дадлагажигчийг түр болон байнгын ажилд авч буй аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжинэ. Бизнес эрхлэгчдийн зүгээс дөнгөж төгссөн залуусыг туршлагагүй, ур чадваргүй гэх мэт шалтгаанаар ажилд авдаггүй. Тиймээс энэ хандлагыг өөрчлөхөөр төсөлд залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зүйл заалтыг тодорхой тусгасан. Тэрчлэн боловсролын

тал дээр хувь хүний ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарна. Ялангуяа, даяаршиж буй энэ нийгэмд залуус хамгийн багадаа 1-2 хэлийг эзэмшсэн байх шаардлага тулгарч байгаа. Мөн сайн дурын ажил эрхэлдэг залуусыг үнэлэх систем бий болгохоор зорьж байна. Жишээлбэл, оюутан байхдаа сайн дурын ажил хийсэн бол их, дээд сургуулиа төгсөөд ажлын байранд очиход ажиллаж байсан гэсэн тодорхойлолт болох эрх зүйн зохицуулалтыг хийхээр зорьсон.

-Сүүлийн үед залуус гарааны бизнест хүч үзэх болсон. Тэдний бизнесийн орчныг дэмжих талаар хуулийн төсөлд ямар зүйл заалт оруулсан бэ? -Өөрсдийн санаачилгаар гарааны бизнес эрхэлж байгаа залуусыг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэхээр хуулийн төсөлд тусгасан. Тодруулбал, шинээр гарааны бизнес эрхэлж

байгаа залууст жижиг, дунд үйлдвэрлэлийн болон тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээл олгоно. -Сүүлийн үед залуусын дунд гэр бүл салалт нийгмийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Энэ чиглэлд хэрхэн ажиллах вэ? -Залуучуудын оролцоо хөгжлийг дэмжих чиглэлд гэр бүлийн боловсрол олгох асуудлыг тусгасан. Судлаад үзэхээр залуучуудын асуудал нь салбар дундынх байдаг. Эрүүл мэндтэй холбоотой асуудал нь Эрүүл мэндийн тухай хууль, дээд боловсрол нь Боловсролын багц хуульд хамаардаг. Тиймээс энэ зохицуулалтыг хангах, орхигдсон зүйлийг Залуучуудын хөгжлийн тухай хуульд нэмж оруулсан. Мөн аймаг, дүүрэг бүрт Залуучуудын хөгжлийн төвтэй байх эрх зүйн зохицуулалтыг хийсэн. Энэ хуулийн дагаад Боловсрол, Эрүүл мэнд, Батлан хамгаалах зэрэг зургаан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. Мөн Ерөнхий сайдаар ахлуулсан Залуучуудын үндэсний хороог байгуулна. -Хуулийн төслийг боловсруулахад залуусын дунд судалгаа хийсэн байх. Манай хүн амын хэдэн хувийг залуучууд эзэлж байна вэ? -Монгол Улсын нийт хүн амын 35.5 хувь нь 15-34 хүртэлх насны залуус байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд нийт ажилгүй иргэдийн 30.6 хувийг залуус эзэлдэг. Харин дээд боловсролтой залуусын тоо өндөр байна. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ
сонин их

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас. 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас. 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртгоцх
Утас. 99901532

Гадаад контент, соёл-энтертайнментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас. 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас. 99903581

ХААГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Бло Скай таур” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас. 70103131,
Факс. 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co
“Чөлөөт хэвлэл”
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч
Б.Даваатогтох

Нийтлэлчийн булан

2025 он гэхэд эмчилгээний марихуанагийн зах зээл 50 тэрбум ам.долларт хүрнэ

Ази, Европын олон оронд хүмүүс олсны ургамлыг сүсэг бишрэл, зан үйлийн зориулалтаар ашиглахын зэрэгцээ толгой өвдөх, гэдэс түгжрэх, өвчин намжаах зэрэг уламжлалт эчилгээнд өргөн хэрэглэдэг. Хүн төрөлхтөн олсны ургамал тариалсан түүх 3000 жилийн өмнөөс эхтэй тул Ойрхи Дорнод, Арабын зарим оронд улаан буудай, тутаргатай зүйрлэхүйц ариун ургамалд тооцогдоно.


МАРИХУАНА МООД БОЛСОН НЬ

Олсны ургамлыг ад үзэх нөхцөл АНУ-д өнгөрсөн зууны 20-иод

бүтээгдэхүүний Дюпон концерн, Анслингерийн анд, шар хэвлэлийн суутан Уильям Рендольф Херст нарын цаастай холбоотой бизнес эрхлэгчид нуугдаж байсанд гайхалтгүй. Газрын тос, химийн компаниуд байгалийн гаралтай мяндсыг шахаж чадахуйц нийлэг мяндас хөгжүүлэхэд хөрөнгө хаяж байлаа.

Ауслингер олсны ургамлыг арьс өнгө, нийгмийн гарал үүслээр ялгаварласан бодлого хэрэгжүүлэх далим болгов. Хобо хэмээх орон гэргүй тэнүүлч, Мексикийн цагаач, харууд зэрэг нийгмийн доод давхаргынхны хэрэглээ - марихуана нь гэмт хэрэг, хүчирхийллийн үндэс болж байгааг Анслингер америкчуудын тархинаас гарахгүй болтол нь ойлгуулж өгөв. Марихуанагийн аюулыг шинжлэх ухааны үүднээс батлахын тулд Ауслингер 30 эрдэмтэнд хандаж, судалгаа хийлгэснээс 29 нь каннабисыг хориглох шаардлагагүй гэсэн дүгнэлт хийлээ. Харин Ауслингер үлдсэн ганц нь болох аюултай

Марихуана татахыг хуульчилсан муж улсууд



The New York Times ©

Марихуанатай дайтсан 80 жил

он гэхэд бүрджээ. Нэг наст олсны ургамлаас гаргадаг цаас үнийн хувьд модноос гаргадаг цааснаас хавьгүй хямд байсан нь Америкийн мод боловсруулагчид, цаас үйлдвэрлэгчдийн дургүйг хүргэв. Учир нь олсноос гаргадаг цаасны үйлдвэрлэлийг ихэвчлэн цагаач мексикчүүд эрхэлдэг байжээ. Олсны ургамал нь байгалийн мяндасны гол түүхий эдийн нэг. Масс үйлдвэрлэлийн анхны автомашин Ford-T загварын кузовны хуванцрыг олсны ургамлаас гаргасан мяндсаар хийдэг байлаа. Хэнри Форд анх уг загварын хөдөлгүүрийг хүртэл олсны ургамлын тосоор ажиллуулж байв.

Байгалийн мяндас нь нефть химийн компаниудын урагшлах замд саадтай түүхий эд. АНУ-ын Конгресст олсны ургамлын тариаланг хориглох лобби өрнүүлэгчдийн ард хими, эмийн

гэсэн дүгнэлтийг л ашигласан юм. Лобби хэрэгэ гаргаж, 1937 он гэхэд Конгресс марихуанагийн тариаланг дааж давшгүй өндөр татвар тогтоосноор уг ургамал АНУ-ын хэмжээнд хэрэг дээрээ хориотой таваар болж хувирав. Дайнд АНУ ялж, олсны ургамал ялагдав.

ДЭЛХИЙ НИЙТИЙГ ХАМАРСАН НЬ

Дэлхийн II дайнаас хойш, 1960-аад оны үеэс марихуанаг эсэргүүцэх хөдөлгөөн дэлхий нийтийг хамарлаа. АНУ-ын Дээд шүүх 1937 оны Конгрессын шийдвэрийг үндсэн хууль зөрчсөн үйлдэл гэж үзсэн тул Ерөнхийлөгч Никсоны үед буюу 1971 онд хууль тогтоох байгууллага шинэчилсэн шийдвэр гаргасан нь олсны ургамлын эсрэг тэмцлийг бүр ч чангатгав.

НҮБ 1961 онд “Мансууруулах бодисын нэгдсэн конвенц” баталснаар каннабис нь дэлхийн мансууруулах бодисын жагсаалтад багтжээ. Олсны ургамалд тавих хяналтыг чангатгах, тариаланг нь бүрэн хориглох, хууль бусаар ургуулсан каннабисыг устгах, баривчилгаа явуулахыг гишүүн орнуудад үүрэг болголоо. НҮБ-ын гишүүн улсууд гарын үсэг зурснаас хойш 25 жилд багтаан олсны ургамлыг эмнэлэг, шинжлэх ухааны зориулалтаас өөрөөр ашиглахыг бүрмөсөн хориглохоор уг конвенцод зааж өгчээ. Гэхдээ байгалийн мяндас гаргах зориулалтаар олсны ургамал тариалахыг уг конвенц зөвшөөрсөн юм. НҮБ-ын шийдвэрийн дагуу олсны ургамлыг мансуурах зорилгоор ашиглахыг өрнөдийн орнууд төдийгүй Ойрхи Дорнод, Азийн орнууд ч хориглов.

Гэтэл марихуана хэрэглэгчдийн тоо АНУ-д ч, дэлхийн хэмжээнд ч буурсангүй. АНУ 1937 онд холбооны хэмжээнд марихуанаг хориглож байх үед уг ургамлын талаар дуулаа ч үгүй хүн олон байжээ. Марихуана хэрэглэгчдийн ихэнх нь уг ургамлыг хэдэн зууны турш татаж ирсэн уламжлал бүхий Мексиктэй хил залгаа Техас зэрэг цөөн мужид байдаг байв. Эдүгээ марихуана АНУ төдийгүй дэлхийд хамгийн эргэлтгүй мансууруулах бодис болсныг сүүлд явуулсан судалгаа харуулж байна. НҮБ-ын судалгаагаар зөвхөн 2008-2013 онд дэлхийн мансууруулах бодис хэрэглэгчийн нийт тоо 203 саяас 246 сая болж өссөн дүнтэй. Үүнээс 158.8 сая нь буюу манай гаррагийн хүн амын 3.8 хувь нь марихуана хэрэглэгч. АНУ-д явуулсан судалгаагаар тус улсын 100 сая гаруй иргэн

буюу насанд хүрэгчдийн 42 хувь нь амьдралдаа дор хаяж нэг удаа марихуана татаж байснаа хүлээсэн. Нийгмийн доод давхарга, гэмт хэрэгтнүүдийн хэрэглээ хэмээн тайлбарлаж байсан өвс дундаж ангийн хэрэглээ болжээ. Каннабистай хийх тэмцэл төрд дааж давшгүй ачаа болоод зогссонгүй, өөр бусад бэрхшээл үүсгэлээ. АНУ-д өчүүхэн тунгаар марихуана хадгалсан хэрэгээр жил бүр 750 мянган хүнийг баривчилж байгаа нь хууль сахиулах тогтолцоонд дарамт боллоо. Зөвхөн марихуанатай холбоотой баривчилгаа нь АНУ-д мансууруулах бодисын хэргээр баривчилж буй нийт баривчилгааны 40 хувь болж байна.

бусад төрлийн мансууруулах бодисын хууль бус худалдааг зогсоож чаддаггүй юм аа гэхэд бууруулахад тустай хэмээн муж улсуудын удирдлага үзэж байна. Марихуанаг хуульчилж буй нь АНУ-д мансууруулах бодистой тэмцэхэд зарцуулж байгаа олон тэрбум ам.долларыг хэмнэж, “өвс”-нд оноох татвараас олон тэрбумын нэмэлт орлого оруулах сайн талтайг Жорж Сорос тайлбарлаж байлаа.

Марихуана нь өсвөр үеийнхний оюуны чадварыг муутгана хэмээн эмч нар тайлбарлаж байна

ЭСРЭГ, ТЭСРЭГ БАЙР СУУРЬ

“Өвс”-ийг хориглох нь буруу хэмээн үздэг америкчуудын тоо ихэссээр. Хөнгөн мансууруулах бодисын ангилалд багтах марихуанатай тэмцэж хүчрэхгүй болсон тул олсны ургамлыг эмчилгээ, цэнгээний зориулалтаар ургуулах, хэрэглэхийг дэмжихээс аргагүй гэсэн байр суурьтай муж улсууд асар хурдацтай өсөв.

Орчин үеийн ертөнцөд олсны ургамлыг анх хориглосон АНУ эргээд Уругвайтай зэрэгцэн каннабисыг албан ёсоор хуульчилж эхлэв. Өнгөрсөн оны эцсийн байдлаар марихуанаг эмчилгээ, цэнгээний зориулалтаар ашиглахыг хуульчлан зөвшөөрсөн муж улс Колумбын тойргоос гадна 28 болоод байна. “Өвс” татахыг хуульчилж буй муж улсуудыг Обамагийн дарах захиргаа дэмжсэн ч үгүй, эсэргүүцсэн ч үгүй. Латин Америк, Европын улсууд АНУ-ын жишээг дагав.

Архийг хориглосон хуулийг анх 1912 онд АНУ-ын 14 муж улс тус тусдаа мөрдөж эхэлсэн. Харин холбооны улсыг нийтэд нь хамарсан “хуурай” хууль 1920 онд гарсан. Уг хуулийг 1933 онд цуцалсан тул америкчууд 21 жил архитай тэмцээд ялагджээ.

Марихуанаг дарах тэмцэл 1937 онд эхэлсэн гэж үзвэл 80 жил үргэлжилж буй дайн болж таарав. Хааж, хориглохоос илүүтэйгээр, иргэдийн ухамсар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх нь мансууруулах бодистой тэмцэх хамгийн үр дүнтэй арга гэсэн ойлголт дэлхий нийтэд шинэ чиг хандлага болов.

Ахлах сургуульд байхдаа “өвс татаачдын бүлэг”-т харьяалагдаж байснаа номдоо бичсэн ноён Обама марихуанагийн хэрэглээг “хорт зуршил” гэж үзсэн. Гэхдээ марихуанаг архи, тамхинаас илүү болгоныг үзэж мэдэх, танилцах хүсэлтэй. Америкчууд 80 жилийн өмнө марихуанаг хориглоогүйсэн бол Монголд олсны зэрлэг ургамал түүх хүн гарахгүй байж болох байв. Харамсалтай нь эд хар шидэть Өвсөнд манай залуус дурлаад эхэлжээ. Нэгэнт байдал ийм дээр тулсан тул одоо л анхаарах хэрэгтэй. Үгүй бол АНУ хүчрээгүй энэ "дайн"-д дөрөв ч хүрэхгүй сая хүн амтай монголчууд хиараад дуусах биз. Энэ бол монголчуудад өвс зохихгүй. [ЗГМ]

С.ЦОГТБЯАР СУРЖ БАЙНА



Би үйлдвэрлэгч

“Хадаан” Америкт хэдийнэ танигдаж эхэлсэн

Савлагаа,
рекламанд их
мөнгө зарахыг
хүсээгүй

Г.Сайнзаяа
@sainzayaZGM

Монголчууд өөрсдөө үйлдвэрлэгч болсоор байгаа нь бидний амьдралд өнгө нэмж буй. Тэгвэл АНУ-д нэгэн монгол брэнд “мэндэлсэн” нь, тус улсад хэдийнэ танигдаж эхэлсэн сайхан мэдээ байна. Гоо сайхны өндөр зэрэглэлийн бүтээгдэхүүнийг тус улсад үйлдвэрлэж буй Э.Оюунцэцэгтэй ярилцлаа. Тэрбээр “Хадаан” монгол брэндийг үүсгэн байгуулагч юм.



Хувийн архиваас ©

“Хадаан” таны бодол санаанд хэзээ, хэрхэн биелсэн бэ?

–Оюутан цагаасаа л би гоо сайхны бүтээгдэхүүний зах зээлийг их сонирхсон. Охид, бүсгүйчүүдийг гоё сайхан зүйл хэрэглээсэй гэсэндээ гаднын зах зээлд ямар л шинэ бүтээгдэхүүн гарна, түүнийг Монголдоо хямд үнэ өртгөөр авчрахыг боддог байлаа. Тухайн үед Америкаас “Victoria’s Secret”-ийн арьс арчилгаа, хувцас, нүүрний будаг тэргүүнийг авчирсан. Бас нэг шалтгаан нь миний өөрийн арьс эмзэг, харшамтгай болохоор хэр баргийн гоо сайхны бүтээгдэхүүн таардаггүй, хэцүү л дээ. Харин Монголд тэр үед сонголт бага байсан болохоор гадаадаас л байнга захиална, тухай бүрт

зардал их гарна. Харин гурван жилийн өмнө гэр бүлээрээ АНУ-д ирснээр эрэл хайгуул хийж, өөр дээрээ хүртэл туршилт хийх болсон. Улмаар надтай адилхан асуудалтай хүмүүст мэдсэн, сурснаа хуваалцах хүсэл намайг хөтөлсөөр “Хадаан” брэндийн эхлэл тавигдсан юм.

–Нэр нь их өвөрмөц, дотно санагдлаа. Нэрийнх нь талар ярихгүй юу?

–“Хадаан” монгол брэнд болохоор монгол нэр өгөхийг хүссэн. Гэхдээ цаашид зөвхөн Монголдоо бус, дэлхийн зах зээлд ч гаргах зорилготой байгаа болохоор аль ч орны хүн уншихад

түвэггүй нэр сонгосон л доо. Монголын нууц товчоонд гардаг Сорхон шарын охин Хадаан гэж түүхэн хүний нэр.

Дэлхийн тансаг брэндтэй чанараараа эн зэрэгцэнэ

–Одоогоор хэдэн нэр төрлийн гоо сайхны бүтээгдэхүүн гаргасан бэ?

–Уруул өнгөлөгч, хөмсөг, нүд, уруулын харандаа, крем, энгэсэг, сормуусны будаг, уруулын будаг, контур тэргүүтэй нүүрний будаг. Мөн үрчлээний эсрэг өдөр, шөнийн болон зовхины тос гэх мэт арьс арчилгааны иж бүрдэл ч байна. Нийт 50 гаруй нэр төрлөөс “Хадаан” брэнд бүрдсэн.

–Одоогоор хэдэн нэр төрлийн гоо сайхны бүтээгдэхүүн гаргасан бэ?

–Уруул өнгөлөгч, хөмсөг, нүд, уруулын харандаа, крем, энгэсэг, сормуусны будаг, уруулын будаг, контур тэргүүтэй нүүрний будаг. Мөн үрчлээний эсрэг өдөр, шөнийн болон зовхины тос гэх мэт арьс арчилгааны иж бүрдэл ч байна. Нийт 50 гаруй нэр төрлөөс “Хадаан” брэнд бүрдсэн.

–Одоогоор хэдэн нэр төрлийн гоо сайхны бүтээгдэхүүн гаргасан бэ?

–Уруул өнгөлөгч, хөмсөг, нүд, уруулын харандаа, крем, энгэсэг, сормуусны будаг, уруулын будаг, контур тэргүүтэй нүүрний будаг. Мөн үрчлээний эсрэг өдөр, шөнийн болон зовхины тос гэх мэт арьс арчилгааны иж бүрдэл ч байна. Нийт 50 гаруй нэр төрлөөс “Хадаан” брэнд бүрдсэн.

–Одоогоор хэдэн нэр төрлийн гоо сайхны бүтээгдэхүүн гаргасан бэ?



–Одоогоор хэдэн нэр төрлийн гоо сайхны бүтээгдэхүүн гаргасан бэ?

–Уруул өнгөлөгч, хөмсөг, нүд, уруулын харандаа, крем, энгэсэг, сормуусны будаг, уруулын будаг, контур тэргүүтэй нүүрний будаг. Мөн үрчлээний эсрэг өдөр, шөнийн болон зовхины тос гэх мэт арьс арчилгааны иж бүрдэл ч байна. Нийт 50 гаруй нэр төрлөөс “Хадаан” брэнд бүрдсэн.

–Одоогоор хэдэн нэр төрлийн гоо сайхны бүтээгдэхүүн гаргасан бэ?

–Уруул өнгөлөгч, хөмсөг, нүд, уруулын харандаа, крем, энгэсэг, сормуусны будаг, уруулын будаг, контур тэргүүтэй нүүрний будаг. Мөн үрчлээний эсрэг өдөр, шөнийн болон зовхины тос гэх мэт арьс арчилгааны иж бүрдэл ч байна. Нийт 50 гаруй нэр төрлөөс “Хадаан” брэнд бүрдсэн.

–“Монгол эмэгтэйчүүд шоороо, утаа, нар, салхинд ийм хөөрхнөөрөө байгааг нь үнэлэх хэрэгтэй” гэж хүмүүс хошигнодог. Наргиан ч гэсэн энэ үнэн. “Хадаан”-ы арьс арчилгааны бүтээгдэхүүнүүд Монголын уур амьсгалд тохирч чадсан уу?

–“Хадаан”-ы ихэнх бүтээгдэхүүн Монголын хуурай уур амьсгалд тохирсон, нар, салхинаас хамгаалах SPF-ийн найрлагатай. Түүнчлэн арьс арчилгаа болон нүүр будалтын бүтээгдэхүүнүүд маань С, Е аминдэм агуулснаараа давуу талтай. Зөвхөн нүүр будахаас гадна арьсанд тэжээл өгч, нарны хортой туяа, агаар салхины нөлөөллөөс хамгаалах боломжтой.

–Нууц биш бол дараагийн зорилт тань юу вэ. Америкт монгол бүтээгдэхүүнээ сурталчлан таниулах уу, эсвэл дэлхийн технологийг Монголдоо нэвтрүүлж, үйлдвэрлэж энд хийх үү. Америкт хэдийнэ танигдаад эхэлсэн ч байж мэдэх юм?

–Дэлхийн технологийг Монголдоо нэвтрүүлэх бол миний нэлээд том, бас холын зорилгуудын нэг л дээ. Ойрын зорилт гэвэл Америкт брэндээ танилцуулж, Монголын нэрийг гаргах. Мөн “Amazon”-ы онлайн зах зээлд бүтээгдэхүүнээ байршуулж, дэлхийн хаанаас ч захиалах боломж бүрдүүлэхээр ажиллаж

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо. 2017-04-10

Тендер шалгаруулалтын нэр. Тос тосолгооны материал нийлүүлэх 2 багц
Тендер шалгаруулалтын дугаар. МС-29/2017-01

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос тос тосолгооны материал нийлүүлэх 2 багц тус бүрээр нь битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд.

- Борлуулалтын хэмжээ. Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх /2015, 2016 он жил тус бүрээр/
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ. Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх /2015, 2016 он жил тус бүрээр/
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо. 2015он, 2016 он
- Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо. 2015он, 2016 он
- Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл. шаардлагатай

Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо
“ДЦС-4” ТӨХК-ий байр 3 давхар 312, 313 тоот өрөө
Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309, 7000-1357

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо. 2017-04-10

Тендер шалгаруулалтын нэр. Нүүрс тэжээгчийн цагираг ремьн нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар. МС-27/2017-01

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Нүүрс тэжээгчийн цагираг ремьн нийлүүлэх битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд.

- Борлуулалтын хэмжээ. Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх /2015, 2016 он жил тус бүрээр/
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ. Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх /2015, 2016 он жил тус бүрээр/
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо. 2015он, 2016 оныг
- Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо. 2015он, 2016 он
- Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл. шаардлагатай

Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо “ДЦС-4” ТӨХК-ий байр
3 давхар 312, 313 тоот өрөө Утас 7018-1309 7000-1357 7017-1357
Факс 7018-1309 7000-1357

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо. 2017-04-10

Тендер шалгаруулалтын нэр. Резинэн хийц хийж нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар. МС-24/2017-1

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Резинэн хийц хийж нэг үнээр нэг жилийн турш захиалгын дагуу нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд.

- Борлуулалтын хэмжээ. 2015,2016 оны жил бүрийн борлуулалт нь 50,0 сая төгрөгнөөс багагүй байх
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ. 50,0 сая төгрөгнөөс багагүй байх
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан. 2015он, 2016 он
- Ижил төстэй бараа гэрээгээр нийлүүлсэн туршлагын мэдээлэл. 3 жил
- Эх орны үйлдвэрлэгч байна

Тендерийн хамт 1,8 сая /нэг сая найман зуун мянга/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо “ДЦС-4 ТӨХК-ий байр
3 давхар 312, 313 тоот өрөө Утас 7018-1309 7000-1357 7017-1357
Факс 7018-1309 7000-1357

ЗГМ: Сэдэв



Б.Ганбаяр/ЗГМ©

Мэдрэмжгүй мэргэжил сонголт

Нийт төгсөгчдийн гуравны нэг нь мэргэжлээрээ ажилладаг

Энэ байдлаас болоод хүүхдүүд мэргэжлийн чиг баримжаагүй сургуулиа дүүргэж, голдуу ээж, аавынхаа зөвлөснөөр ирээдүйд хэн болох сонголтоо хийдэг байна.

Монгол Улсын хувьд дөрвөн мянга орчим мэргэжлээс байнга сонгодог нь эмч, багш, хуульч, сэтгүүлч. Гэвч эдгээр мэргэжлийн ихэнх нь хөрсөн дээрээ илүүдэлтэй байхад сургуулиуд элсэлт авсаар байна. Мөн гадаадын их, дээд сургуульд тэтгэлэгт хөтөлбөр болон хувийн зардлаар сурч буй оюутнууд ч гэсэн нөгөө л эрэлт хэрэгцээгүй, зах зээлд хахчихсан хуульч, маркетинг, бизнесийн удирдлага, эмч гэсэн мэргэжлээр сурдаг. Хэдий гадаадад боловсрол эзэмшиж байгаа боловч Монголд ирээд бусдын адил ажлын байргүй хоцорно.

Дээд боловсролтой ажилгүй залуус зонхилж байна

Ингээд бодохоор мэргэжил сонголт гэдгийг эргэж нэг хармаар юм. Зарим хүүхдийн тухайд их сургуулийн дипломтой болох л зорилго тавьдаг. Нөгөө талаар хувийн их, дээд сургуулиуд олширсон нь ямар ч хамаагүй мэргэжилтэй больё гэсэн нэгэнд нь мөнгө л байвал дүнгийн цензур тавьдаггүй. Түүнчлэн улсын сургуулиуд босго оноогоо хэтэрхий бага тогтоосон ч залуусын мэргэжил сонголт, цаашлаад улс орны хөгжилд муугаар нөлөөлж мэдэхээр эрсдэл үүсчээ.

1980-аад онд хүн болгон дээд

сургууль төгсөж байгаагүй. Эргээд бодоход тухайн үеийн бодлого зөв байж. Чанартай хэдэн их, дээд сургуультай, тус сургуулийн шалгалтад тэнцсэн нь дээд боловсрол эзэмшээд, чадаагүй нь ТМС-д суралцаж төгсөөд шууд ажлын байртай золгодог. Гэтэл өнөө үед Монголоор дүүрэн мэргэжлийн илүүдэлтэй, дээд боловсролтой ажилгүй залуус зонхилж байна. Мэргэжил сонголтын талаар Баянгол дүүргийн 47 дугаар сургуулийн төгсөх ангийн нэгэн багш “Манай сургуулийн хувьд ямар хичээлдээ сайн, муу гээд сурлагын байдлыг авч үзээд сурагчиддаа зөвлөхөөс биш бидэнд мэргэжил сонголтын талаар гүнзгий ойлголт байхгүй. Тиймээс энэ асуудалд эцэг эхийнх нь байр суурийг илүүд үздэг. Мэргэжил сонголтын тал дээр хэрэгжүүлж буй ажил одоогоор байхгүй” гэв.

Хамгийн сүүлд Монголын оюутны холбооноос 90 гаруй их, дээд сургуулийг жилдээ 30 гаруй мянган оюутан төгсөж, тэдний гуравны нэг нь 4-6 жил сурч эзэмшсэн мэргэжлээрээ ажилладаг гэсэн судалгаа гаргажээ. Харин 60 орчим МСҮТ-ийг жилд 40 орчим мянган оюутан төгсөж, тэдний 80 хувь нь мэргэжлээрээ ажиллаж, үлдсэн хувь нь дэвшин суралцдаг аж.

Мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг тодруулах зорилгоор хамгийн сүүлд 2010 онд үндэсний хэмжээний судалгаа хийсэн бөгөөд нийт 18-25 насны 2500 хүн хамрагджээ. Судалгаанд оролцогчдын зарим нь МСҮТ-ийн сургалтыг сонирхож байсан ч сургалтын чанар муу, төгсөөд ажил олдохгүй гэж хариулсан байв. Түүнчлэн тус сургуулийг төгсөөд амьжиргаа нь сайжирсан, өндөр цалинтай ажилд орсон тухай болон ямар мэдээлэл дутмаг гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Мэргэжил сонголтод тодорхой дараалал, алхмууд байх хэрэгтэй гэдгийг Хөдөлмөрийн төв биржийн мэргэжилтнүүд хэллээ. Тэдний зөвлөснөөр

өөрийн зан байдал, сонирхол, хүсэл мөрөөдөл болон хэн бэ гэдгээ тодорхойлох гэсэн хэд хэдэн алхмын дагуу мэргэжил сонголтыг хийх хэрэгтэй аж. Энэ мэтээр мэргэжил сонголт эртнээс төлөвлөхгүйгээр, өөрийн хүсээгүй мэргэжлийг бусдын хэлснээр, эсвэл тухайн үеийн сэтгэл хөдлөлөөр сонгосноор багагүй асуудалтай тулгардаг. Жишээлбэл, элсэж орсон сургуульдаа сурах сонирхолгүй болж дундаас нь орхих, ингэснээрээ цаг хугацаа болон эдийн засгийн алдагдал

орох, ажлын байргүй, ажиллах сонирхолгүй болох зэрэг сөрөг үр дагавар гардаг байна. Ийн Монголын залуусын мэргэжил сонголт зах зээлийн эрэлттэй нийцэхгүй байгаа юм.

МЭРГЭЖЛИЙГ СУРЛАГА БУС, САЙН ДУРЫН ҮНДСЭН ДЭЭР СОНГОДОГ
Финландын сурагчид сөн жилийн бүрэн дунд сургууль төгсдөг бөгөөд анги дэвшихдээ сургалтын агуулгыг зохих түвшинд заавал эзэмших ёстой. Шаардлагатай гэж үзвэл анги

дэвшилгүй улирч, хичээлээ дахин судална. Сурагчид дунд сургууль дүүргээд ТМС эсвэл ЕБС-д элсэх, эсэхээ сурлагын амжилт бус, харин сайн дурын үндсэн дээр шийддэг.

Финланд улс ард түмнээ боловсролын тэгш боломжоор хангах үүднээс хувийн дунд сургуулиудыг татан буулгаж, улсын сургуульд нэгтгэх арга хэмжээ авчээ. Шинэчлэлийн цогц бодлогын үр дүнд нийтээрээ боловсролын бүх түвшинд тэгш боломжоор хангагдаж, чанартай боловсрол эзэмшсэн ба энэ

нь эдийн засгийн хөгжлийн тулгуур болсон байдаг. Түүнчлэн Америк, Канад болон Европын холбооны улсад хүн бүр дээд боловсрол эзэмших шаардлага байдаггүй. Тодруулбал, өндөр шилэн барилгын цонхыг угаахад, цэцгийн дэлгүүрт ажиллахад, зочид буудлын үйлчлэгч, нийтийн тээврийн жолооч, хүүхэд асрагч, барилгын ажил зэрэгт дээд боловсрол шаардагддаггүй. Учир нь тэдгээр хүмүүсийн амьдралд тухайн ажил мэргэжлээс авдаг цалин хөлс нь хүрэлцээтэй байдаг. [ЗГМ]

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Ц.Цацрал: Хүүхдүүдэд өгч буй зөвлөгөө, мэдээлэл үр өгөөжгүй байдаг



Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид мэргэжил сонголт хэрхэн хийх талаар БСШУСЯ-ны Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Сургалтын хөтөлбөр, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Ц.Цацралаас тодрууллаа.

-Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад зориулсан мэргэжил сонголтын талаар зөвлөгөө, мэдээлэл хангалттай өгч чаддаг уу?

-Одоогийн байдлаар ЕБС төгсөгчдөөс мэргэжил сонголттой холбоотой тодорхой судалгаа, түүний үр дүнд чиглэсэн үйл ажиллагаа дутмаг байна. Мэргэжлээ зөв сонгохын ач холбогдолыг төгсөх ангийн сурагчид төдийлэн ойлгохгүйгээр хэн нэгний зөвлөгөө, эсвэл уламжлалт

мэргэжил буюу эцэг эхийнхээ мэргэжлийг өвлөх, найз нөхдөө дагах зэргээр сонголт хийдэг. Энэ нь мэргэжлээрээ ажиллахгүй байх, ажилгүйчүүдийн тоог нэмэх шалтгаан болдог. Төгсөх ангийн сурагчдад зориулан намраас хавар хүртэлх хугацаанд маш олон төрлийн өдөрлөг, сургалт зохион байгуулдаг хэдий ч ихэнх нь аль нэг сургуулийн сурталчилгаа, эсвэл манлайлын тухай лекц байдаг бөгөөд үр өгөөж муутай л даа. Тиймээс БСШУСЯ-ны харьяа байгууллагууд төгсөгчдөд зориулан зөвлөгөө, мэдээлэл хүргэж байгаа. Одоогоор Өмнөговь, Дархан-Уул аймаг болон Багануур дүүрэгт "Мэргэжил таны ирээдүйд" хэлэлцүүлэг зохион байгуулж эхлээд байна.

Төгсөгчид их, дээд сургууль, коллеж, МСҮТ сонгохдоо хайнга ханддаг

-Та бүхний энэхүү ажил бусад энэ төрлийн арга хэмжээнээс ямар онцлогтой вэ?

-Төгсөгчдөд уран яруу гоё яриа, аль нэг сургуулийн рекламнаас илүү салбарын бодит мэдээлэл хэрэгтэй гэж бид үзсэн юм. Төгсөх ангийн сурагчдад өөрийгөө таньж цаашдаа ажиллаж, амьдрах мэргэжлээ зөв сонгох, элсэлтийн ерөнхий шалгалтаа амжилттай өгөх, үүний дараа сургуулиа зөв сонгох, оюутан болоод сургалтын төлбөрийн асуудал, ямар тэтгэлгүүд байдаг вэ? гэсэн асуудлууд гарч ирдэг. Бидний энэхүү арга хэмжээ нь эдгээр асуудалд цогц байдал хариулт өгч буйгаараа онцлог. Жишээлбэл, төгсөгчид маань их, дээд сургууль, коллеж, МСҮТ сонгохдоо хайнга ханддаг. Заримдаа "за одоо сонголтгүй боллоо" гээд ямар ч хамаагүй магадлан итгэмжлэгдээгүй сургуульд элсдэг. Ингээд дөрвөн жил сурч төгсөөд гадагшаа мэргэжил дээшлүүлэхээр магистр, доктор явах гэхэд өмнөх шатны боловсрол нь хүлээн зөвшөөрөгдөхгүй байх тохиолдол бий. Ингээд дахиад эхнээс нь сурах шаардлага тулгардаг. Цаг хугацаа болон эдийн засгийн хувьд хохирдог. Ийм учраас бид төгсөгчдөд олон талын хэрэгтэй мэдээллийг нь бүрэн өгч өөрт нь сонголтыг үлдээх хэрэгтэй байгаа юм. [ЗГМ]

ЗГМ:НЭГ АСУУЛТ

-Мэргэжлээ хэрхэн сонгож байгаа вэ. Энэ талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?



Нийслэлийн 77 дугаар сургуулийн 12 дугаар ангийн сурагч А.Энхтулга:

-Мэргэжил сонголтын талаарх мэдээллийг гэр бүл, хамаатан садангаасаа авдаг. Ерөнхийдөө мэргэжлээ сонгохдоо хэн нэгний хэлснээр биш өөрийн сонирхлын дагуу сонгосон. IT инженер болохоор шийдсэн.



Нийслэлийн 48 дугаар сургуулийн 12 дугаар ангийн сурагч Ц.Номин:

-Мэргэжил сонголтын талаарх мэдээллийг багш нар, гэр бүлээсээ авдаг. Өөрийнхөө хүссэнээр мэргэжлээ сонгож байгаа боловч эцэг эхийн нөлөөлөл байгаа. Миний хувьд эмчийн мэргэжлийг сонгосон.



Хөгжим бүжгийн коллежийн 12 дугаар ангийн сурагч Х.Биндэрьяа:

-Мэргэжил сонголтын талаарх мэдээллийг гэр бүл, цахим ертөнцөөс авдаг. Мэргэжил сонгоход гэр бүлийнхэн нөлөөлсөн. Эдийн засагч мэргэжлээр сурахаар төлөвлөсөн. [ЗГМ]

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ҮЗЭСГЭЛЭНГ “МИАТ” ӨНГӨЛЛӨӨ

Далайд гарцгүй, өргөн уудам нутаг дэвсгэртэй, дэд бүтэц сул хөгжсөн манай орны хувьд агаарын тээврийг гадаад ертөнцтэй холбогдох гол гарц гэж үздэг. Ийм ч учраас агаарын харилцааг үндэсний аюулгүй байдлын тулгуур хүчин зүйл гэж үзэн эдийн засгийн тэргүүлэх чиглэлд тооцдог. Энэ

салбарт гаднын орны тээвэрлэгчидтэй “бор зүрхээрээ” өрсөлдөж байгаа Үндэсний гэх тодотголтой агаарын тээвэрлэгч маань өнөөдрийн байдлаар Ази, Европын найман чиглэлд тогтмол нислэг хийж байна. Зургадугаар сараас шинээр Бусан руу нислэг үйлдэх гэж байгаа бөгөөд ерөнхийдөө жилд дунджаар хагас сая гаруй зорчигч тээвэрлэдэг байна. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд ашигтай ажиллаж чадсан МИАТ компани энэ үзэсгэлэнг ях

аргагүй “өнгөлж” байлаа. Монгол Улсын нэрийн хуудас болж яваа энэ байгууллагын олон улсад өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх, үйл ажиллагааны цар хүрээг нь тэлэхэд төр засгаас бодлоготойгоор дэмжээд өгвөл Монголыг дэлхийтэй холбон аялал жуулчлалыг хөгжүүлэх гол гүүр болж, эх орны эдийн засгийн хөгжилд илүү их хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.



Спорт

Сэлүүрт завины амьд домог

ДАШТ-ийг хоёр-дугаарт тавьж, зөвхөн олимпод анхаарлаа хан-дуулж байжээ

Б.Тэмүүлэн
ЗГМ

Махе Дрисдейл анх сэлүүрт завины төрлөөр дагнан хичээллэх шийдвэр гаргахдаа өөрийгөө энэ спортоор од болно гэж бодоогүй нь лавтай. Харин өдгөө 38 настай Махе энэ хугацаанд сэлүүрт завины ганцаарчилсан төрөлд хоёр олимпын аваргаар тодорч, дэлхийд тавантаа түрүүлээд байна.

Тэрбээр Австралийн Мельбурн хотод 1978 оны арваннэгдүгээр сарын 18-нд мэндэлжээ. Хүүхэд байхдаа сэлүүрт завины сонирхдоггүй байж. Харин их сургуульд ороод энэ спортын талаар анхны мэдлэгтэй болжээ. Махе хэдийгээр Мельбурнд төрсөн ч Шинэ Зеландын иргэншилтэй юм. Сонирхуулахад, Сейшелийн хамгийн том арал болох Махе нэрийг түүнд эцэг, эх нь хайрлажээ.

Залуу хүү эхэндээ их спортоор тууштай хичээллэх бодолгүй байж. Зүгээр л сонирхогчийн хэмжээнд бэлтгэл хийдэг байсан хэрэг. Гэтэл түүний бодлыг Сиднейн олимп өөрчилж орхив. Сэлүүрт завины ганцаарчилсан төрөлд нутаг нэгт Роб Водделл нь түрүүлж, алтан медаль хүртэхийг хараад түүн шиг амжилт гарган алдаршихыг хүсчээ. Энэ шийдвэр ч зөв байв. Учир нь Махе завины спортод төрөлхийн авьяастай нэгэн байсан юм. Тухайлбал, сэлүүр гартаа барьж, мэргэжлийнхэнтэй өрсөлдөж эхэлсэнээ хойш ердөө жилийн дараа эх орноо төлөөлөн Дэлхийн



BBM©

цомын тэмцээнд оролцжээ. Ийм богинохон хугацаанд ингэж хурдан сайжирсан тамирчин харж байсангүй хэмээн тухайн үед дасгалжуулагч нь магтаж байсан

гэдэг. Өндөр түвшинд уралдаж эхэлсэн даруйдаа медаль аваад байгаагүй нь ойлгомжтой. Түүнд сурч, сайжруулах зүйл маш их

байв. Гэхдээ түүний амжилт жилээс жилд өсөж байлаа. Улмаар Афины олимпод оролцох эрхээ авсан нь түүнд итгэл найдвар хайрласан юм. Дөрөвхөн жилийн

өмнө нутаг нэгт олимпын аваргыг харж, түүн шиг тамирчин болохыг мөрөөдөж байсан бол одоо өөрөө эх орноо төлөөлөн оролцох гээд зогсож байв. Харамсалтай нь, Махе ба түүний нөхөд Афины усан замд хангалттай хурдан байж чадсангүй. Түүний уралдсан дөрвөн хүнтэй баг финалд шалгарсан ч тэргүүлэгчээс есөн секуннд хоцрон тавдугаар байрт бичигдлээ. Ингэж тэр олимпын дэвжээ хатуу гэдгийг мэдрэв.

Харин дараа жилийнх нь ДАШТ-д анхны томоохон амжилтаа үзүүлээ. Японы Гифү хотод болсон 28 дахь удаагийн ДАШТ-ий ганцаарчилсан төрөлд Дрисдейл 7.16.42 минутын амжилтаар тэргүүн байр эзэлж, төрийнхөө дууллыг эгшигчлүүлэв. Эндээс л түүний амжилтын түүх эхэлсэн юм.

Нэгэнт хийдгээ хийсэн тул сэлүүрт завиа орхиж буйгаа зарлажээ

Дараагийн хоёр жилд дэлхийн аварга баталж, медалийн цуглуулгаа нэмэв. Ийнхүү дэлхийд гурвантаа аваргалсан Махе Бээжингийн олимпод түрүүлэх ганцхан зорилготой очлоо. Шинэ Зеландын ард түмэн ч түүнийг түрүүлнэ гэдэгт бүрэн итгэж, нээлтийн ажиллагаанд тугчаар оролцуулсан юм. Харамсалтай нь, Норвегийн Олаф Туфте, Чехийн Андрей Сынек түүнээс хурдан байсан тул дөнгөж хүрэл дээр буужээ. Финалын уралдаанаас долоо хоногийн өмнөөс түүний холоод гэдэс хямарч, хүч тамираа барсан нь өөрийн хэмжээнд уралдахад саад болсон юм. Магадгүй урд хөрийн хоол түүнд зохиогүй биз ээ.

Ногт ганзагалаж очсон наа-

дамдаа гэнэтийн ялагдал хүлээсэн нь түүнийг бэлтгэлээ улам шаргуу хийхэд хүргэлээ. Дараа жилийнх нь ДАШТ-д Махе замаа 6.33.35 хугацаанд туулж, дэлхийн дээд амжилтыг тогтоов. Эүүрл саруул үедээ ямар хэмжээнд уралдаж чадахаа харуулсан нь хамгийн чухал байв. Түүний онцгой амжилтыг Шинэ Зеландын Үндэсний олимпын хороо үнэлж, оны шилдэг тамирчнаар нэрлэсэн юм.

Гэхдээ үүнээс хойш Махе өндөр түвшинд уралдаж чадахгүй л байлаа. 2010, 2014, 2015 оны ДАШТ-дазгүйгэж, мөнгөн медаль л зүүв. Гол өрсөлдөгч нартаа удаа дараа ялагдах түүнийг “харьж байна” гэж дүгнэх боллоо. Харин Махе ДАШТ-ийг хоёрдугаар ээлжинд тавьж, зөвхөн Риогийн олимпод анхаарлаа хандуулжээ. Ингээд Бразилын олимп эхлэх үед оргил формондоо ороод байв.

Сэлүүрт завины эргэтийчүүдийн ганцаарчилсан төрөлд 33 орны шилдгүүд хүрэлцэн иржээ. Махе урьдчилсан шат, шөвгийн найм болоод хагас шигшээд урдаа хэнийг ч оруулсангүй. Ингээд финалд шилдэг зургаан тамирчин өрсөлдөхөд тэрбээр бүгдээс түрүүлэн барианд орж, Лондоны олимпын алтан медалиа хамгаалсан юм. Чехийн А.Синек түүнтэй маш ширүүн өрсөлдөж, ялагчийг фото финишээр тодруулжээ. Ингэж тэрбээр олимпын наадмаас гурав болон түүнээс дээш медаль авсан Шинэ Зеландын ес дэх тамирчин болсон юм. Мөн түүнийг И.Фергюсон, П.Макдоналд, П.Снелл нараас хойш төрсөн хамгийн агуу тамирчин гэж шинэ зеландчууд үздэг юм.

Нэгэнт хийдгээ хийж, гавьяагаа байгуулсан Махе Дрисдейл энэ жил сэлүүрт завиа орхиж буйгаа зарлажээ. Их спортоор оройтож хичээлсэн ч их амжилтыг үзүүлсэн түүний түүх олон хүнд нэгийг бодогдуулах биз ээ. [ЗГМ]

МЭДЭГДЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭД



Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль, НӨАТ-ын тухай хууль хэрэгжиж эхэлснээр 2016 оны төсвийн татварын орлого төлөвлөснөөс 487,1 тэрбум төгрөгөөр түүний дотор нэмэгдсэн өртгийн албан татварын орлого өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 70.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба сүүлийн 20 жилд анх удаа татварын орлого бүх төрлөөр биелсэн байна. Мөн 2017 оны эхний 3 сард татварын орлого 30%-иар давж биеллээ. Үүнээс дүгнэхэд татварын эрх зүйн орчны шинэчлэлийн системийн эхлэл тавигдаж, үр дүнд нь эдийн засаг хүндрэлтэй байгаа хэдий ч төсөвт төвлөрөх татварын орлого зөвхөн 2016 оны 1 сарын 1-нээс өнөөдрийг хүртэлх хугацаанд 800 тэрбум төгрөгөөр давсан байна.

Ийнхүү татварын суурь өргөжиж, татварын орлого бүрдүүлэхэд нааштай үр дүн гарч байгаа энэ үед Засгийн газраас төсвийн зардлыг нэмэгдүүлэх, тэтгэврийн насыг нэмэх, түүнчлэн 2016 оны намрын чуулганаар хэлэлцүүлж байсан татвар нэмэх асуудлыг Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжүүлэх нэрийн дор 2017 оны төсвийн тодотголтой хамт УИХ-д өргөн барьж байгаатай холбогдуулан бизнесийн төлөөллийн гол байгууллагын хувьд МҮХАҮТ дараах санал, шаардлагуудыг хүргүүлж байна. Үүнд :

Төсвийн зардлыг 2017 оны батлагдсан төсвөөс огт нэмэгдүүлэхгүй байх. Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тодотголоор нийт зарлага ба цэвэр зээлийг батлагдсан түвшнээс 220.7 тэрбум төгрөгөөр нэмсэн байна;

Төрийн захиргааны албан хаагчдийн тоог 20%, үйлчилгээний албан хаагчдийн тоог 10%-иар тус тус бууруулах. 2012 оноос хойш төрийн албан хаагчдийн тоо ойролцоогоор 15 хувь буюу 24 мянгаар өссөн байна. Мөн төрийн албан хаагчдийн шаардлагагүй зардал, нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмжийг зогсоох;

Нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэхгүй байх. Эдийн засаг хямралтай, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого буурсан хүнд нөхцөл байдалд НДШ-ийг нэмэгдүүлэх нь ажлын байр буурах, улмаар ядуурал ихсэх нөхцөл болно;

Хувь хүний орлогын албан татварыг нэмэгдүүлэхгүй байх; Тодорхой салбарт дэмжлэг үзүүлэх, зарим барааны үнэ тогтворжуулах нэрийн дор зах зээлийн зарчмаар тэгш, шударга өрсөлдөх боломжийг хааж буй татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг үзүүлэхгүй байх;

Онцгой албан татварыг нэмэгдүүлэхгүй байх; Төсвөөс татаас авдаг, алдагдал өндөртэй төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, татан буулгах асуудлыг яаралтай шийдвэрлэх;

Тэтгэврийн насыг үе шаттай нэмэх асуудалд тооцоо, судалгаатай хандан шийдвэр гаргах. Энд баталгаатай ажлын байртай төрийн 183 мянга гаруй албан хаагчдийн тэтгэврийн насыг нэмэх асуудлыг төр өөрөө мэдэж зохицуулах боломжтой ч чөлөөт зах зээлд ажиллаж байгаа 1 сая гаруй иргэд баталгагүй, тогтворгүй ажлын байранд ажилладаг гэдгийг онцгойлон анхаарах шаардлагатай. Мөн монгол хүний насжилт, салбарын онцлог, ажлын байрны нөхцөл, тогтвортой байдал зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзэх хэрэгтэй.

Иймд Улсын Их Хурал 2017 оны төсвийн тодотголыг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө УИХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг гарган дээрх шаардлагуудыг судлан шийдвэрлэхийг УИХ-ын дарга М.Энхболд, УИХ-ын эрхэм гишүүдээс шаардаж байна.

Бизнес эрхлэгчдээс тавьж байгаа эдгээр шаардлагуудыг хүлээн авч нааштай шийдвэрлээгүй тохиолдолд 2017 оны 4 сарын 10-нд төлөх 3 дугаар сарын Нэмэгдсэн өртгийн албан татвар, 4 сарын 15-нд төлөх 1 дүгээр улирлын ААНОАТ, 5 сард төлөх 4 сарын Нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхгүй байхыг нийт аж ахуйн нэгжүүдэд уриалахаа мэдэгдэж байна.

МҮХАҮТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТЭРГҮҮЛЭГЧИД
2017.04.05

БОУЛИНГ

Багануурын боулингчид шилдэг нь байв

Б.Энхжин
ЗГМ

Боулинг сонирхогчдын хамгийн том тэмцээн болох “Холбооны цом” өнгөрсөн бямба гаригт “Big Bowling” төвд боллоо. “City Cup” болон “Coca Cola Zero Championship” тэмцээний эхний найман байрт орсон шилдэг 16 баг оролцдог болохоор тэмцээний нэр хүнд өндөр, тэр хэрээр өрсөлдөөн ширүүн байдаг. Энэ жилийн тэмцээнд Г.Төмөрбаатар ахлагчтай “Багануур” ХХК-ийн баг тамирчид анх удаагаа аваргаар шалгарлаа. Урьдчилсан тоглолтод 16 багаас хамгийн өндөр оноо авч, нэгээр шалгарсан тэд халз

тоглолтод ганц ч хожигдолгүй явсаар түрүүлсэн юм.

2014 онд Багануур дүүрэгт усан бассейн, боулингийн төв шинээр байгуулагдсан. Энэ үеэс хойш Багануурын тамирчдын амжилт эрс дээшилж, тэмцээнд дээгүүр өрсөлдөх багт нэрлэгдэх болсон. Улмаар шилдгүүд өрсөлдсөн “Холбооны цом”-д аваргалж, анхны том амжилтаа гаргаж байна.

Мөнгөн медалийн эзнээр Г.Магсаржалам ахлагчтай “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн баг шалгарсан бол Д.Амьбөх ахлагчтай СЭЗИС-ийн баг хүрэл дээр буусан юм. Энэ баг өнгөрсөн жилийн тэмцээнд түрүүлж байсан билээ. Тэмцээний шилдэг тамирчнаар

“V darts” хэмээх шинэ багийн П.Одхүү 245 оноогоор шалгарлаа. Энэ удаагийн тэмцээнд шинэ залуу тамирчид хүчтэй өрсөлдсөнөөрөө онцлог боллоо. Монголын спортын сэтгүүлчдийн холбооны баг шөвгийн наймд Багануурын багтай тун ойрхон өрсөлдөж, ердөө 20-хон онооны зөрүүтэй хожигдсон юм.

Мөн тус тэмцээнд тасралтгүй оролцсоор ирсэн Их Британийн ЭСЯ-ны баг тамирчдад Монголын боулинг сонирхогчдын холбооны өсөн талархлын өргөмжлөл, дурсгалын зүйлс гардуулсан. Тус улсын үе үеийн Элчин сайд нар нь өөрсдөө багаа тэргүүлэн “Холбооны цом”-ын тэмцээнд оролцсоор иржээ. [ЗГМ]

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хийгдэхээр төлөвлөгдсөн сургууль цэцэрлэг, авто зам, инженерийн шугам сүлжээний ажлын хүрээнд газар чөлөөлөлтөд өртөх нэгж талбаруудын газар болон үл хөдлөх хөрөнгө, эд хөрөнгийн үнэлгээний ажил хийх шаардлагатай болсон тул уг ажлыг хийх аж ахуйн нэгж, байгууллага нь үнийн санал /нэг нэгж талбарт хийх/, тусгай зөвшөөрөл, өөрсдийн ажлын болон мэргэжилтнүүдийн ур чадварыг нотлох баримт бичгийг хамт ирүүлнэ үү.

Үнийн саналыг 2017 оны 04 дугаар сарын 14-ний өдөр 14.00 цагаас өмнө Нийслэлийн Газрын алба, Чингэлтэй дүүрэг 1-р хороо Хангарьд ордон 401 тоотод ирүүлнэ үү. Үнийн саналыг 2017-04-14-ний өдрийн [14 цаг 30 минут] -т нээнэ.

“Нийслэлийн Газрын алба”

Лавлах

ЭРЧИМ ХҮЧ Цахилгааны ХӨНГӨЛӨЛТ ХЭВИЙН ГОРИМД ШИЛЖЛЭЭ

З.Цэлмэг
ЗГМ

Гэр хорооллын айл өрхүүд энэ сараас эхлэн цахилгааны шөнийн хэрэглээний төлбөрийг тооцох хэвийн горимд шилжлээ. Өөрөөр хэлбэл, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын айл өрхүүдийн цахилгааны шөнийн 700 кВт.ц хүртэлх хэрэглээг тэглэж байсан хөнгөлөлт энэ сарын 1-нээс эхлэн дуусгавар болов.

Ингэснээр хоёр тарифт тоолууртай айл өрхүүдийн шөнийн хэрэглээг урьдын адил кВт.ц тутамд 77.1 төгрөгөөр тооцож эхэлнэ гэсэн үг. Гэр хорооллын тодорхой бүсүүд дэх айл өрхүүдийн цахилгааны 21.00-06.00 цагийн 700 кВт.ц хүртэлх хэрэглээний төлбөрийг 100 хувь хөнгөлөх шийдвэр нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн бөгөөд гуравдугаар сарын 31-нд дуусаж байгаа юм. [ЗГМ]

ХАМТЫН АЖИЛЛАГАА Олдворуудаа Өмнөд Солонгост дэлгэнэ

Хууль бусаар хил давуулсан үлэг гүрвэлийн чулуужсан олдворуудыг манай улсад эргүүлэн өгөх ёслол баасан гарагт Сөүл хотод болжээ.

Ёслолын үеэр Монголын Засгийн газраас Өмнөд Солонгосын талд талархаж буйгаа илэрхийлэн, олдворуудыг тус улсын ард иргэдэд дэлгэж, удаан хугацаагаар түрээслүүлэх санал тавьсан байна. Олдворуудыг хаана, хэдий хугацаагаар байрлуулахаа ойрын хугацаанд тодорхой болгож, хариу өгнө гэдгээ Сөүлийн тал мэдэгджээ.

Эдгээр олдворыг 2014 оны тавдугаар сард нэг монгол, хоёр солонгос иргэн хууль бусаар хил давуулсан юм байна. Олдворын дотор зөвхөн манай газар нутгаас олддог Тарбозавр батаарын болон Протоцератопсын яс, чулуужсан өндөгнүүд байгааг тус улсын прокурор онцолжээ. [ЗГМ]

Зөвлөгөө Бүжиг суралцах чадварыг тэтгэдэг

Психологистууд буюу сэтгэх хэл шинжлэлийн мэргэжилтнүүд хүний хоёр дахь, эсвэл гурав дахь хэл нь вербал бус хэл байвал суралцах чадвар төгс нээгддэгийг олж мэджээ. Ийм хэлний гол төлөөлөгч нь бүжгийн хэл юм. Энэ утгаараа бүжгийг зөвхөн урлаг, эсвэл зугаа цэнгэл гэж үзэх нь хангалтгүй. Бүжиг бол хөгшин, залуу хэнд ч адил ач холбогдолтой боловсрол аж.

Бүжиглэхэд хүний тархинд мэдрэлийн шинэ эсүүд үүсдэг бөгөөд эдгээр эс нь хоорондоо холбогдох тусам хүний мэдлэг олж авах, сэтгэн бодох чадвар гойд сайжирдаг. Мөн зарим мэдрэлийн эс түргэссэнээр төв мэдрэлийн тогтолцоонд ч нэвтрэх боломжтой болдог байна. Ийнхүү мэдрэлийн эс хэр зэрэг уян хатан байна хүн амьдралынхаа туршид төдий чинээ өөрчлөгдөх боломж, чадвар өндөр байдаг нь тархи хийгээд бүжгийн гайхамшигт хослол юм.

Бүжиглэх үед тархинд ялгардаг уураг нь ой тогтоолт, суралцахууд шаардлагатай мэдрэлийн эсийн өсөлт хөгжил, уян хатан байдлыг дэмждэг. Ингэснээр эерэг сэтгэл хөдлөл нэмэгдэж, стрессийг даван туулахад ч мөн тусалдаг аж. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	09.00 "Тюльпан" УСК	08.00 "Bloomberg Daybreak Asia"	08.00 ЕБС-ийн теле хичээл	09.30 "Тог тог тог" /season-3/ 115 дугаар хэсэг
12.00	11.00 "Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр	11.00 #Made in Mongolia. Трансвест Монголиа ХХК	11.15 Тамирын багш ОАК 2. 19-20 дугаар анги	12.00 "Хөтөч" мэдээллийн хөтөлбөр
14.00	14.30 120/80 эрүүл мэндийн хөтөлбөр	14.00 "Хөгжилд хүрсэн түүх" нэвтрүүлэг	14.05 "Үүнийг хэрхэн хийдэг вэ" нэвтрүүлэг	14.00 "Бригад" нэвтрүүлэг 29 дүгээр хэсэг
18.00	17.00 "Зөв зөв" цэнгээнт нэвтрүүлэг	17.30 "Bloomberg Surveillance"	18.05 "Бяцхан оцон шувуу Пороро" 1.41-44 дүгээр анги	18.30 "Нүүдэл шийдэл" нэвтрүүлэг
20.00	19.30 Эрх зүйн хөтөч	20.00 "Алсын хараа" нэвтрүүлэг	20.35 "Зургаан настнууд бидний ирээдүй" нэвтрүүлэг	20.00 "Оргил цаг" мэдээллийн хөтөлбөр
22.00	21.05 "Нандин" ток шоу	21.00 "Мөнгөний урсгал" хөтөлбөр	22.00 "Хайр эргэсэн хавар" ОАК 11 дүгээр анги	22.30 "Чадвал намайг хуур" ОАК 13 дугаар анги

ОНЦЛОХ ҮЗВЭР

"Травиата"



Монгол Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрын тайзнаа анх 1977 онд тоглож байсан "Травиата" дуурийг энэ сарын 15-нд дахин тоглох гэж байна. Гурван бүлэг, дөрвөн үзэгдэлтэй уг дуурийг урлагийн гавьяат зүтгэлтэн Ё.Цэрэндолгор найруулж, удирдаачаар урлагийн гавьяат зүтгэлтэн Н.Туулайхүү ажиллаж буй аж. "Травиата" дуурийг анх гол баатрын нэрээр "Виолетта" хэмээн нэрлэж байсан бөгөөд 1853 онд Италийн Ла Фенис театрт нээсэн гэдэг. Цомнолыг хүү Александр Дюмагийн "Камелийн цэцэгт хагагтай" зохиолоос сэдэвлэн Ф.М.Пьяве бичсэн бөгөөд Верди, Пьяве нар Дюмагийн зохиолын утга, агуулгыг дагаж, орчин үед тохируулан хийхийг хүссэн боловч захиалагч Ла Фенис театраас дуурийн үйл явдлыг өнгөрсөн зуунаар байлгахыг хатуу шаардсан байна. Тиймээс 1880-аад оныг хүртэл уг бүтээл жинхэнэ түүхийн хугацаагаар харуулж чадаагүй аж. Өнөөдөр "Травиата" дуурь дэлхий дахины театруудын урын санд томоохон байр эзэлдэг билээ. [ЗГМ]

ҮЗВЭР

"АЗ ХУР"

Хүүхэд, багачуудад зориулсан "Үлгэрийн цаг" хөтөлбөр ням гараг бүрийн 13.00 цагт болно. Энд хүрлэн ирснээр монгол ардын болон дэлхийн сонгодог үлгэрүүдийг үнэ төлбөргүйгээр хүүхдэдээ сонгох боломжтой.

УДЭЗТ

П.И.Чайковскийн алдарт "Хунт нуур" балетыг энэ сарын 16-нд 17.30 цагаас тоглоно. Балетмейстерээр ардын жүжигчин Б.Жамъяндагва ажиллаж буй бөгөөд гол дүрүүдийг соёлын тэргүүний ажилтан О.Анужин, соёлын тэргүүний ажилтан О.Ганцоож нар амилуулах аж. Тасалбарын үнэ 10-30 мянган төгрөг. Мөн энэ сарын 22-нд 17.00 цагаас Ж.Пуччингийн дэлхийн сонгодог дуурь болох "Чио чио сан", 23-нд Л.Минькусын "Дон кихот" балетыг тоглоно.

УЛСЫН ФИЛАРМОНИ

"Novel Melody" хөгжмийн концерт энэ ням гарагт 19.00 цагаас Улсын филармонийн тайзнаа эгшиглэнэ. Улсын филармонийн Морин хуурын чуулгыг соёлын тэргүүний ажилтан Д.Түвшинсайхан удирдана.

УЛААНБААТАР ЧУУЛГА

Хөгжим бүжгийн коллежийн цохивор хөгжмийн шилдэг уран бүтээлчид 10 жилийн турш найруулж, тоглож ирсэн 100 гаруй бүтээлээс хамгийн шилдэг 20 бүтээлээ сорчлон, "НАЙРУУЛГА 2007-2017" хаалтын хүндэтгэлийн гала концертоо энэ сарын 21, 22-нд үзэгчдэд хүргэх гэж байна. Цохивор хөгжмийн тоглолт 10 жилийн хугацаанд Монголын төдийгүй дэлхийн олон алдартай бүтээлийг шинэчлэн найруулж Монголын үзэгчдэд хүргэж ирсэн билээ.

URGOO CINEMA IMAX

Алдарт "Fast&Furious" киноны наймдугаар анги энэ сарын 14-нөөс гарч эхэлнэ.

ЗУРХАЙ




Билгийн тооллын 14

Хаврын дунд харагчин туулай сарын нэг цагаан мэнгээтэй улаагчин туулай өдөр. **Үс засуулбал.** Эд мал арвижна. **Наран ургах, шингэх.** 05.15-19.34 **Барилдлага.** Үл зохилдох **Шүтэн барилдлага.** Төрөн түгэхүй

Аргын тооллын дөрөвдүгээр сарын 10, Сумъяа гараг. Билгийн тооллын 14, Тугчин одтой, улаагчин туулай өдөр.

Өдрийн наран 06.15 цагт мандан, 19.34 цагт жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, уул овоо тахиад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвижна.

ЗГМ. ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР.
1. Дэлхийн шигшмэл морьдын уралдаанд түрүүлсэн "Мон-

golian Saturday" морины эзэн, тод манлай уяач
2. Унаа, тээвэр
3. Үрнээс нь тос гаргаж авдаг жимс
6. Байгал нуураас эх авч, хойд зүгт урсдаг гол мөрөн
7. Италийн хөлбөмбөгийн алдартай баг
8. Хархорин сумын нутагт байдаг эртний сүм хийд
9. Дэлхийн хамгийн том арлыг эзэмшдэг улс


ХӨНДЛӨНГӨӨР.
2. Нүгэлт муу үйл хийгч
4. Барьцаалан зээлдүүлэх газар
5. Сансарт анх ниссэн хүн
10. Жюль

Вернийн нэгэн зохиолын баатар, ахмад
11. Амь бөхтэй аюултай мэргэч
12. Амьтан барих хэрэгсэл


Өмнөх дугаарын хариу / 04.07




ЗГМ. СҮДОКУ



ЦАГ АГААР



ЗГМ: КОМИКС



[ЗГМ]

"ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" Сонины онлайм захиалга үргэлжилж байна.

"ZGM-FINANCIAL TIMES" ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД 5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ Сонины нийтлэл, мэдээ, сурвалжлагатай ХОЛБООТой САНАЛ ХҮСЭЛТЭЭ

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ		
Эрээн-УБ	18.00	11.15
Хөххот-УБ	22.50	11.15
УБ-Хөххот	20.00	20.49
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20
Эрхүү-УБ	15.35	06.20
УБ-Сүхбаатар	21.15	05.12
Сүхбаатар-УБ	20.55	05.03
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48
Замын-Үүд-УБ	17.35	08.55
УБ-Замын-Үүд	17.20	07.05

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ		
УБ-Бээжин	06.10	08.25
УБ-Ханбумбат	07.30	08.40
УБ-Токио	07.55	13.40
УБ-Сөүл	08.45	12.50
Бээжин-УБ	09.30	12.00
Ханбумбат-УБ	09.30	10.35
Сөүл-УБ	14.20	16.50
Токио-УБ	14.40	19.10
Ханбумбат-УБ	22.00	23.05
УБ-Ханбумбат	20.00	21.10

Сурталчилгаа



Шинэ элсэлтүүдийн бүртгэл явагдаж байна!

БИДНИЙ ТУХАЙ

“АБСОЛЮТ” төв нь 2001 онд БСШУЯ-ны тусгай зөвшөөрөлтэй байгуулагдсан цагаасаа Монголын мянга мянган залуусын англи хэлний боловсролд өөрийн хувь нэмрийг дорвитой оруулан бусдыгаа чанараараа дагуулсаар ирлээ. Энэ хугацаанд 30000 гаруй оюутан залуус манайд суралцаж төгссөн юм. Бид англи хэлний бүх шатнаас TOEFL, IELTS-ийн түвшинг дүүргэтэл өөрийн оюутнуудаа бэлтгэн төгсөгчид маань шалгалтандаа жигд өндөр оноо авч жил бүр рекорд амжилт шинэчлэн тогтоож, тэтгэлгээр суралцах ямар ч шалгалтанд заавал тэнцдэг. Манай ажлын үр дүн суралцагчдын маань гаргасан амжилтаар хэмжигдэж энэ хугацаанд 1000 гаруй оюутан залуус дэлхийн топ сургуулиудад Засгийн газар хоорондын, сангуудын, тухайн сургуулиудын гэх мэт тэтгэлгүүдэд хамрагдаж суралцаж чадлаа. Одоо тэд маань эх орондоо эргэн ирж тухайн салбартаа манлайлагч болж ажиллаж эх орны хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа нь бидний бахархал юм.

ХАМТ ОЛОН

Олон улсын TEFL, TESOL зэрэгтэй англи хэлний мэргэжлийн гадаад, монгол багш нар, багш нарын заах аргын ур чадварын уралдаан, багш нарын ажил мэргэжлийн аварга, арга зүйч, докторант, магистр монгол багш нар ажилладаг.

ХОЛБОО БАРИХ

Хаяг : СБД, 8-р хороо, Тусгаар Тогтнолын Ордон
108 тоот.
Утас: 7711-8288, 328288.
www.facebook.com/AbsoluteToeflCenter

ДАВУУ ТАА

- ✓ Суралцагчид нь TOEFL, IELTS-ийн шалгалтуудад хамгийн өндөр оноог авдаг.
- ✓ Сонсгол, ярианы чадвар сайжруулах хичээлүүдийг англи, америк багш нар, олон улсын TESOL зэрэгтэй гадаад багш нар 100% заадаг.
- ✓ Англи хэлний бүх шатны түвшингээс TOEFL, IELTS-ийн шалгалтуудад хамгийн шилдэг тусгай хөтөлбөрөөр бэлтгэж өгдөг.
- ✓ TOEFL ITP-ийн албан ёсны оноотой төгсгөдөг.
- ✓ TOEFL, IELTS-ийн хамгийн сүүлийн шилдэг сурах бичгүүдийг сургалтандаа ашигладаг.
- ✓ Бямба гараг бүр TOEFL, IELTS-ийн загвар тест, гадаад үг цээжлэх цуврал хичээлүүд явагддаг.
- ✓ Бямба, ням гараг бүр 100% гадаад багштай ярианы клуб хичээллэдэг.
- ✓ АНУ-д хэл шинжлэлийн чиглэлээр магистр, Англид бакалавр хамгаалсан, АНУ-д мэргэжил дээшлүүлсэн олон улсын TEFL зэрэгтэй монгол багш нар, АБСОЛЮТ төвийн үндсэн гадаад багш нарын хүчирхэг баг хичээлийг заадаг.

СУРГАЛТЫН ТӨРӨЛ

- ✓ TOEFL iBT, IELTS-ийн шалгалтанд бэлтгэх сургалтууд
- ✓ Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу өндөр хөгжилтэй орнуудад 100% тэтгэлгээр суралцуулах шалгалтанд бэлтгэх сургалт
- ✓ Цаашид гадаадад тэтгэлгээр суралцах хүсэл зорилготой хүүхэд залуусыг англи хэлний анхан, дунд шатнаас эхлэн TOEFL iBT, IELTS-ийн шалгалтад тусгай хөтөлбөрөөр бэлтгэх сургалтууд
- ✓ Байгууллагын захиалгат сургалт
- ✓ 100% гадаад багштай яриа дүрэм хосолсон сургалтуудыг тогтмол хичээллүүлж байна.

АБСОЛЮТ-н 2016 оны амжилтуудаас



АБСОЛЮТ-н төсөгч Т.ДЭЛГЭРМАА
IELTS 7 оноо
Швейцарь.



АБСОЛЮТ-н төсөгч М.ХЭВЛАН
IELTS 7 оноо



АБСОЛЮТ-н төсөгч Н.ЛҮРЦАЙХ
IELTS 7 оноо



АБСОЛЮТ-н төсөгч С.ДӨЛГӨӨН
IELTS 7 оноо



АБСОЛЮТ-н төсөгч П.АРИУНАА
IELTS 8 оноо
Nagoya University, 100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төсөгч Ө.ЭНХЖИН
IELTS 8 оноо
Nagoya University, 100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төсөгч В.ЯНЖИНДХАМ
IELTS 7.5 оноо
DAAD Герман, Берлин



АБСОЛЮТ-н төсөгч Ю.ӨНӨБӨЛД
IELTS 7.5 оноо
Maharashi University of Management



АБСОЛЮТ-н төсөгч О.ЧИНСАНЧИР
IELTS 7.5 оноо



АБСОЛЮТ-н төсөгч Э.ГИЛГҮТЭЙ
IELTS 7.5 оноо



АБСОЛЮТ-н төсөгч Б.АНХЧИМЭГ
IELTS 7.5 оноо



АБСОЛЮТ-н төсөгч Ц.НОМИН
IELTS 7 оноо



АБСОЛЮТ-н төсөгч Б.БИЛГҮҮН
TOEFL iBT 117 оноо
МУ Засгийн Газрын 100% тэтгэлэг,
University of California



АБСОЛЮТ-н төсөгч А.БЕЛГҮҮН
Niaiyin Institute of Technology
100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төсөгч Б.БАЙГАЛЬ
TOEFL iBT 105 оноо
Хятадын Засгийн Газрын 100% тэтгэлэг
Nanjing Forestry University



АБСОЛЮТ-н төсөгч Б.ОТГОНБЯАР
Унгарын Засгийн Газрын 100% тэтгэлэг
University of Miskolc



АБСОЛЮТ-н төсөгч Х.СҮХ
University of Taiwan
100% тэтгэлэг



АБСОЛЮТ-н төсөгч Э.ОЛБЯАР
Унгарын Засгийн Газрын 100% тэтгэлэг
University of Debrecen



АБСОЛЮТ-н төсөгч Б.БАТЭМҮҮЛЭН
TOEFL iBT 105 оноо
МУ Засгийн Газрын 100% тэтгэлэг,
University of Washington



АБСОЛЮТ-н төсөгч Б.ЦЭНГҮҮНЖАВ
IELTS 7 оноо

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Тохиролцохоос цааргалж буй технологийн компаниуд

АНУ-ын хуулиар социал сүлжээний компаниуд контентод хяналт тавих үүрэг хүлээх ёсгүй. > 10

Сирид өгсөн АНУ-ын цохилтын учир

Томагавкийн цохилт нь байлдааны өргөн цар хүрээтэй ажиллагааны оршил болох нь цөөнгүй. > 10

Венесуэлийн жагсагчид сонгуулийг наашлуулахыг шаардлаа

Сөрөг хүчний удирдагчийн төрийн алба хаших эрхийг 15 жилээр хассан нь эсэргүүцэлтэй тулгарав. > 10

Б.Жонсон Москвад хийх айлчлалаа цуцлав

Катрин Хилле

Британийн Гадаад хэргийн сайд Борис Жонсон АНУ Сирид пуужингийн цохилт өгсний дараа Москвад хийх айлчлалаа цуцаллаа. Тэрбээр шинэ нөхцөл байдалд Сирийн талаар бодлогоо Вашингтонтой уялдуулахын тулд ийм шийдвэр гаргасан хэмээн тайлбарлав. Ноён Жонсон хэлэхдээ “Сирид өгсөн цохилт нөхцөл байдлыг үндсээр нь өөрчиллөө” гээд даваа гарагт болох Их долоогийн уулзалтын өмнө АНУ-тай хэлэлцээ хийх нь чухал боллоо гэсэн байна. Их долоогийн орнууд Сирид гал зогсоох, улс төрийн үйл явцыг эхлүүлэх асуудлыг хэлэлцэхээр төвлөжээ.

Жонсон цааш нь “Дээрх төлөвлөгөөг АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсонтой хэлэлцсэнийг дурдаад Америкийн сайд лхагва гарагт Москвад айлчлахдаа тодорхой уялдаатай байр суурийг Оросын талд хүргэх болно хэмээсэн юм. Энэхүү мэдэгдэл нь Сири дэх химийн довтолгооны дараа ОХУ улам бүр хүнд нөхцөлд орохын дохио боллоо гэж ажиглагчид үзэж байна. Сирийн Засгийн газраас үйлдсэн гэх уг довтолгооны дараа Америкийн цэргүүд Сирийн нисэх буудлыг

пуужингаар харвасан билээ.

Вашингтон болон өрнөдийн бусад улс Сирийн Ерөнхийлөгч Башар Асадын хүчин химийн дайралт үйлдсэн хэмээн буруутгаж байгаа. Гэвч Сирийн онгоцууд бөмбөгдөх үеэр босогчдын химийн зэвсгийн агуулахаас мэдрэлд нөлөөлдөг хий алдагдсанаас энгийн иргэд амь үрэгдсэн гэж үзсэн. Москва баасан гарагт АНУ-ын пуужингийн цохилтыг “Зохиомол шалтгаар тусгаар улсын эсрэг хийсэн түрэмгийлэл” гэж нэрлэсэн юм.

Британийн Гадаад хэргийн сайд Борис Жонсон энэ талаар “Энгийн иргэд амь үрэгдээд байхад хүртэл Оросын тал Башар Асадыг өмгөөлж байгаад харамсаж байна” хэмээв. Тэрбээр цааш нь “Бид Орост хандаж, Сирид улс төрийн тохиролцоонд хүрэхэд боломжтой бүхнийг хийхийг уриална. Өнгөрсөн долоо хоногийн цочирдом үйл явдлыг дахин гаргахгүйн тулд олон улсын хамтын нийгэмлэгтэй харилцан ажиллана” гэж мэдэгдлээ. Борис Жонсоны Москвад хийх айлчлал сүүлийн таван жилд Британийн Гадаад хэргийн сайдын анхны айлчлал болох байсан юм. Гэвч айлчлалыг цуцалснаар Украин болон Сирийн мөргөлдөөнөөс

Жонсон “Энхийн төлөвлөгөөг АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсонтой хэлэлцсэнийг дурдаад Америкийн сайд лхагва гарагт Москвад айлчлахдаа тодорхой уялдаатай байр суурийг Оросын талд хүргэх болно хэмээсэн юм.



BVM©

болж эвдэрсэн байсан харилцааг засах найдвар талаар боллоо.

Трампын засаг захиргааны зүгээс Сирийн талаар шийдвэртэй алхам хийсэн нь Оросын талаас Асадыг дэмжсэн цэргийн ажиллагаагаа хумих төлөвлөгөөг бусниулж буй бололтой. Москва Иран ба Турктэй тохиролцсоны үндсэн дээр хэсэгчлэн гал зогсоох гэрээ байгуулж, Асадыг тодорхой хугацаанд засгийн

эрхэнд үлдээхийг санаархаж байсан билээ. Эхэндээ АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп ийм төлөвлөгөөг үл эсэргүүцсэн байр суурьтай мэт байсан.

Гэхдээ Америкийн пуужингийн цохилт нэг удаагийн цэргийн арга хэмжээ юу, эсвэл Асадыг засгийн эрхээс нь зайлуулах өргөн ажиллагааны эхлэл үү гэдэг нь тодорхойгүй байна. Москвагийн ивээл дор

Сирийн энхийн асуудлаар Казахстаны нийслэл Астана хотод хэлэлцээр явагдсан. Мөн Женев хотод НҮБ-ын дэмжлэгтэй хэлэлцээ үргэлжилж буй. Өрнөдийн ажиглагчид АНУ-ын идэвхгүй байр суурийн улмаас Москва хэлэлцээнд давуу тал олж авсан гэж үздэг.

Ирэх лхагва гарагт Москвад хийх АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга ноён Тиллерсоны

айлчлалаар Кремль Сирийн энхийн үйл явцад Вашингтоны дэмжлэгийг авна гэж найдаж байсан юм. Гэвч “АНУ-ын пуужингийн цохилт Сирийн хэлэлцээний үйл явцыг үр дүнтэй урагшуулах боломжийг хүндрүүллээ” гэж Оросын Гадаад хэргийн дэд сайд Геннадий Гатилов мэдэгджээ.

FT



ХААН БАНК

БҮСГҮЙЧҮҮДЭД ЗОРИУЛСАН МОНГОЛЫН АНХНЫ ХАМГИЙН ЗАГВАРЛАГ “GLAMOUR” КРЕДИТ КАРТ ГАРЛАА

2017 оны 04-р сарын 10 өдөр, Даваа гараг, УБ хот.

ХААН Банкнаас Монголд анх удаа бүсгүйчүүдэд зориулсан “Glamour” кредит картыг шинээр нэвтрүүллээ.

Монголд анхлан нэвтрүүлсэн тус кредит картын дахин давтагдашгүй загварыг Монголын загварын салбарын тэргүүлэх дизайнерууд болох Michel&Amazonka нар урлаж, үндэсний уламжлалт хээг цэцгийн дэлбээтэй хослуулан төгс зохицлыг бий болгожээ. Орчин үеийн эрхэмсэг бүсгүйчүүдэд зориулсан “Glamour” кредит картын нээлт 2017 оны 04-р сарын 07-ны өдөр болж, салбар бүрийн

манлайлагч бүсгүйчүүд цугласан нь “Glamour” үдшийг улам тодотгож байв.

Нээлтийн үеэр ХААН Банкны Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч Р.Мөнхтуяа “Манай банкны нэвтрүүлж буй “Glamour” карт нь Монгол бүсгүйчүүдэд зориулсан анхны кредит карт төдийгүй загварын агентлагтай хамтран бүтээсэн гэдгээрээ анхдагч боллоо. Энэхүү зээлийн эрхтэй “Glamour” кредит карт нь бүсгүйчүүдийн онцлог хэрэгцээ, амьдралын хэв маягт нийцсэн олон давуу талуудыг олгож байна” хэмээн дурдлаа.

Картын загварыг урласан Michel&Amazonka

брэндийн үүсгэн байгуулагчид “Glamour” кредит картын загварыг ур ухаан, авьяас чадвараа зориулан бүсгүй хүний гоо үзэсгэлэнд нийцүүлэн тусгайлан бүтээлээ” хэмээн онцлов.

Эрхэм бүсгүй та дэлхийн хаана ч ашиглах боломжтой, бэлэн мөнгөний эрсдэлгүй, 15 сая хүртэлх төгрөгийн зээлийн эрхтэй, нэр бүхий худалдаа үйлчилгээний байгууллагад худалдан авалт хийгээд буцаан олголт, хөнгөлөлт урамшуулал авах боломжтой “Glamour” кредит картын тухай дэлгэрэнгүй мэдээллийг www.khanbank.com болон 33-30-30 утсанд хандан аваарай.

Glamour

кредит карт

ҮЛЭМЖ ТӨГӨЛДӨР БҮСГҮЙ ТАНД ЗОРИУЛАВ



Glamour кредит карт захиалахыг хүсвэл:

33 30 30
утсанд хандана уу.

www.khanbank.com

creditcard@khanbank.com
и-мэйл хаягт хүсэлт илгээнэ үү.

ХААН Банкны өөрт ойр салбарт хандана уу.

**Мадумита Муржиа,
Хелен Уоррел**

Экстремизм, бусдыг гадуурхах явдал ихсэж буй өнөөгийн нөхцөлд онлайн хэрэглэгчдийн биеэ авч явах байдалд технологийн компаниуд хариуцлага хүлээх, эсэх нь ноцтой асуудал болж хувирлаа. Их Британийн парламентын доод танхимын гишүүд баасан гарагт Google, Facebook, Twitter компанийн төлөөлөгчдийг хүлээн авч, бусдыг доромжилсон онлайн материалуудад тохирсон арга хэмжээ авахаас цааргалж буй явдалд ширүүн донго хүртээлээ.

Вестминстерт болсон халдлагыг үйлдсэн этгээд аллага үйлдэхийнхээ өмнө Facebook-ийн WhatsApp ашигласан нь тодорхой болсноос хойш долоохон хоноод энэхүү шүүмж өрнөжээ. “Террористуудад холбоо барих нууц газар” олгодог явдлаа зогсоохыг Дотоод хэргийн сайд Амбер Радд саяхан мэдээллийн компаниудаас шаардлаа.

Технологийн компаниуд өөрсдийн платформуо нарийн хянах шаардлагыг улстөрчдөд шаргуу тавьсан хэвээр. Харин компаниуд шаардлагатай арга хэмжээг хэдийнэ авсан, цаашид хөндлөнгийн оролцоо хэрэггүй гэсэн тайлбар өгдөг. Үүнтэй холбогдуулан шийдвэрлэх зохих таван асуудлыг дор жагсаав.

1. Цахиурын хөндийн олон нийтийн мэдээллийн платформууд түүхээсээ либерал, чөлөөт сэтгэлгээтэй. Бүх л платформ интернэтэд тавигдаж буй зүйлсэд аливаа хэлбэрээр хяналт, шалгалт тавихыг эсэргүүцэж ирсэн уламжлалтай. Google, Twitter, Facebook нь хэрэглэгчдэдээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, уралдуулахыг аль болох дэмждэг. Контентод хяналт тавихдаа хойрго байдаг бас нэг шалтгаан нь олон нийтийн мэдээллийн компаниуд аливаа либерал бус, автократ засаглалын өмнө өвдөг сөхрөх дургүй явдал.

“Бусдыг доромжилж болзошгүй гэдэг хүмүүсийн уг яриаг боогоод байвал үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө суларч буй нь тэр. Гэхдээ онлайн орчинд хэн ч бусдыг доромжлох эрхгүй, ийм үзэгдэл манай платформд байх ёсгүй” хэмээн Twitter-ийн захирал Жэкс Дорси



BBM©

Тохиролцохоос цааргалж буй технологийн компаниуд

тайлбарласан.

2. Хяналт тогтоох ёстой олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь хамрах цар хүрээний хувьд хэт аварга. Ийм ч учраас олон янзын контент шинээр гарч, тархах хурдтай хөл нийцүүлэн хяналт тавих нь хүний хүчин чадлаас хэтэрсэн зүйл. Жишээ нь, YouTube-т минут тутамд 400 цагийн видео контент, Twitter-т өдөртөө 500 сая жиргээ шинээр нэмэгдэж байна. Хэрэглэгчид Facebook-т өдөр болгон 350 сая фото тавьгааж байна.

“Өдөр бүр хэдэн тэрбумаар тоологдох пост, тайлбар, мессеж нэмэгдэж буй нөхцөлд бид бүгдийг нь шалгаж үнэхээр шаардлагатай гэж үзвэл устгадаг байх нь зүйтэй хэмээн олон нийтийн мэдээллийн компаниуд тайлбарлаж байна. YouTube

Иймд хэрэглэгчид өөрсдөө технологи ашиглан зохисгүй контентыг шалгаж, шаардлагатай гэж үзвэл устгадаг байх нь зүйтэй хэмээн олон нийтийн мэдээллийн компаниуд тайлбарлаж байна. YouTube

зэрэг компани хэрэглэгчдээс гомдол ирүүлсэн контентуудыг 24 цагийн дотор шалгадаг.

3. Алгоритм нь шийдвэрлэх хэрэглүүр биш. Бусдыг доромжилсон бичлэг, материалыг машин-технологи ашиглан автоматаар арчиж хаях нь өөрийн дутагдалтай. Яг л хүмүүний нэгэн адилаар, ийм технологи нь бусдыг дайрч давшилсан бичлэгийг учир зүйн үндэс бүхий шүүмж, эзлэглэл материалаас тэр бүр ялгаж чадахгүй. Хүүхдийн порнограф гэх мэт хориотой контент, зохиогчийн эрх зөрчсөн материалыг машин технологи дүрсээр нь шууд таньж болох. Харин экстремист, хэт даварсан үзэл бодол бүхий контентыг ялгаж ойлгох нь үүнээс хамаагүй хэцүү.

“Барууны үзэл баримтлалтай санвагартны номлолыг бусадтай хуваалцах, шашны утга агуулгатай материалыг хянах зэрэг нь толгой эргүүлсэн асуудал. Тухайн контентыг чухам юугаар нь экстремист утгатай гэж үзэх нь хүмүүсийн хувьд ч хүнд. Тэгэхээр ийм

асуудал нь компьютерт ахадсан “ажил” хэмээн Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд дүн шинжилгээ хийх төвийн захирал Жэйми Барлетт тайлбарлав.

Технологийн компаниуд контентод анализ хийж, гаж зүйлсийг нь илрүүлэх чадвартай хиймэл оюун ухаан хөгжүүлэхээр ажиллаж байна. Жишээ нь, “Мэдээллийг харьцуулан, террорист агуулгатайг нь ялган тодорхойлох чадвартай хиймэл оюун хөгжүүлж байгаа. Ийм технологи амжилттай хэрэгжиж чадвал террорист бүлэглэлүүд шинэ гишүүн дайчилж амжихаас нь өмнө тухайн контентыг бид устгаад явна” хэмээн ноён Закерберг мэдэгдсэн. Гэхдээ мэдээлэл уншиж, ойлгодог хиймэл оюун ухаан бүтээх нь технологийн талаасаа хүнд ажил гэдгийг давхар анхааруулсан юм.

4. АНУ-ын хуулиар, компаниуд контентод хяналт тавих үүрэг хүлээх ёсгүй. АНУ-д интернэт орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, инновацийг хамгаалахтай холбоотой хууль зүйн орчныг Мэдээлэл холбооны ёс

зүйн хуулиар зохицуулдаг. Уг хуулийн дагуу контентод хүлээх хариуцлагыг платформд нь бус, олон нийтийн мэдээллийн хэрэглэгч нарт нь хүлээлгэсэн. Аливаа контентыг эрх баригчдаас хуулийн дагуу авч хаях шаардлага тавихгүй л бол, тухайн платформыг эзэмшигч компани хариуцлага хүлээх ёсгүйг хуулиар тодорхой зааж өгчээ.

“Ийм зарчим үйлчилдэггүйсэн бол хуульчид аливаа контентыг нийтлэгдэхээс нь өмнө шалгаж байхаас аргагүй болно. Хуульчид бусдыг гүтгэсэн, хэт даварсан, зохиогчийн эрх зөрчсөн материал бүрийг шалгаж байна гэж төсөөлөөд үз. Шалгаж амжихгүй учраас платформ оршин тогтнох ч аргагүй” хэмээн ноён Барлетт өгүүлээ.

5. АНУ-ын технологийн компаниуд Европын орнуудын Засгийн газрын шахалтад тийм ч хялбар автахгүй. Их Британийн Дотоод хэргийн яам технологийн компаниудыг хууль сахиулах байгууллагуудтай нягт хамтран ажиллуулахаар хэд хэдэн удаа

яриа хэлэлцээ өрнүүлсэн. Гэтэл Google, Facebook зэрэг АНУ-ын компани дэлхий нийтийг хамарсан аварга цар хүрээтэй хэрэглэгчдийн өмнө хариуцлага хүлээдэг. Ийм компаниудтай Британийн парламентын гишүүдийн өмнө нэр хүндээ болдог дотоодын компаниудтай адил харьцах аргагүй. “Глобал компаниудтай тохиролцох нь тун хүнд. Учир нь ийм аваргууд манайхны компаниуд шиг хууль зүйн нэгдмэл орчинд ажилладаггүй” хэмээн Скотланд Ярдны комиссар Крэг Макки Вестминстерийн халдлагын дараахан тайлбарлаж байлаа.

Түвэгтэй асуудал зөвхөн Их Британид тулгараад байгаа ч юм биш. Бусдыг занаж зүхсэн болон хуурамч мэдээллийг устгаагүй тохиолдолд олон нийтийн сүлжээний компанийг 50 сая хүртэл еврогоор торгох хууль батлах талаар ХБНГУ-ын Засгийн газар саяхан мэдэгдсэн. Одоогоор Германы жижгээ дагасан Европын өөр улс хараахан гараагүй байна.



Сирид өгсөн АНУ-ын цохилт

Сэм Жонс

Башар Асадын дэглэмд өгсөн АНУ-ын цохилт нь Вашингтон ямар ч үйл ажиллагаа явуулахад бэлэн болохоо харуулж, хүчээ ойлгуулах зорилготой арга хэмжээ байв. Баасан гарагт орон нутгийнхаар 16.40 цагт АНУ Газар дундын тэнгист байрладаг хоёр хөлөг онгоцноос Шайрат дахь Сирийн нисэх хүчний бааз руу 59 ширхэг Томагавк далавчигт пуужин харвав. Томагавк нь Булангийн дайнаас хойш АНУ-ын сүр хүчээ харуулах гол зэвсэг байж ирсэн юм. Уг пуужин нь 2500 километр хүртэлх зайд тусгалтай тул америк цэргийн амь насанд хөнөөлгүйгээр цохилт өгөхөд тохиромжтой зэвсэг болдог. Томагавк нь ихэнх радарт баригдалгүйгээр, нам өндөрт,



BBM©

дуунаас бага хурдтай нисдэг. Вашингтоны цохилтын цар хүрээ нь сүүлийн үед далавчигт пуужин ашиглан хийсэн бусад цохилтоос онц ялгарах юмгүй. Өрнөдөд террорист халдлага үйлдэх төлөвлөгөөтэй хэмээн сэжиглэж байсан, Аль-Кайдагийн Хорасан бүлэглэлийн Сири дэх

байрлал руу Вашингтон 2014 онд 47 ширхэг Томагавк харвасан юм. Томагавкийн байлдааны цэнэгт хошуу нь 450 килограмм тэсрэмхий бодистой. Энэ удаагийнх шийр олон пуужин нэг дор харвах тохиолдолд ямар ч хуягласан бэхлэлтийг ядах юмгүй устгаж болно.

Байлдааны илүү өргөн цар хүрээтэй ажиллагааны оршил болох нь цөөнгүй тул Томагавкийн цохилтыг АНУ-ын цэргийн “жадны гилбэр” хэмээн нэрлэдэг. АНУ энэхүү пуужинг 2011 онд Ливид явуулсан байлдааны ажиллагааны эхний шатанд өргөн хэрэглэсэн. Энэ удаагийн цохилтыг гүйцэтгэсэн USS Porter, USS Ross байлдааны хоёр хөлөг нь 2003 онд Саддам Хусейний дэглэмийг устгах дайны үеэр Иракийн нутаг руу пуужин харваж байжээ.

АНУ байлдааны ажиллагаагаа цаашид өргөжүүлэх магадлал бий. Газар дундын тэнгист байрлаж буй хөлгүүдэд далавчигт пуужингийн нөөцөөс гадна цохилтын бусад зэвсгийн нөөц их байгаа. Нисэх онгоц тээвэрлэгч

George HW Bush хөлөг Персийн буланд байрлаж байна.

Шайрат дахь нисэх хүчний баазыг довтолсон нь Асадын дэглэмийг сулруулна. Гэхдээ дэглэмийг сүйрүүлсэн цохилт болж чадахгүй. Цохилтоор чухам юу устгасан, Сирийн Засгийн газар юуг нь аюулгүй авч үлдэв гэдэг одоогоор тодорхойгүй. ОХУ-ын цэргийн техник хэрэгслийг устгахаас сэргийлэн уг цохилтын талаар Москвад урьдчилан анхааруулсан талаар Вашингтоны албаны хүмүүс тайлбарлаж байгаа. Москва уг мэдээллийг Сирийн холбоотондоо дамжуулсанд эргэлзэх шинжээч цөөн.

ОХУ-ын байлдааны нисэх онгоц, цэргийн албан хаагчид урьд нь Шайратыг байнга

ашигладаг байсан юм. Дамаскаас умарлад Хомс мужид, Ливаны хилд ойр оршдог уг баазыг Сири, ОХУ-ын Засгийн газар иргэний дайнд оролцогч босогчдын эсрэг агаарын цохилт өгөхөд идэвхтэй ашиглаж иржээ. ОХУ уг баазыг өнгөрсөн онд “бэхжүүлэн сайжруулах” арга хэмжээ авсан. Учир нь ОХУ-ын байлдааны нисдэг тэрэг Шайратыг буудлаа болгон ашигладаг байлаа.

АНУ нь Сирийн эрх баригч дэглэмийн цэргийн хүчин чадлыг сулруулах зорилгоор Шайратыг байгаа болгожээ. Хан Шейхун дахь иргэдийг хорт хийгээр довтолсон Сирийн байлдааны онгоцууд Шайратаас хөөрсөн хэмээн АНУ-ын тагнуулын байгууллага үзэж байгаа юм.



Венесуэлийн жагсагчид сонгуулийг наашлуулахыг шаардлаа

Андрес Шипани

Өнгөрсөн амралтын өдрүүдэд Венесуэлийн хотуудад жагсагчид гудамж талбайг дүүргэн, урьдчилсан сонгууль явуулахыг шаардлаа. Ерөнхийлөгчид өрсөлдөх боломжтой сөрөг хүчний нэг гол удирдагчийг хууль бус хэрэгт буруутгасан нь өргөн хэмжээний эсэргүүцлийн шалтгаан болжээ. 2014 онд сөрөг хүчний хэдэн арван хүн амь үрэгдсэн хүчтэй эсэргүүцлийн хөдөлгөөнөөс хойш Венесуэлд ийм өргөн олныг хамарсан жагсаал цуглаан болоогүй.

Срөг хүчний удирдагч агаад хоёр удаа Ерөнхийлөгчийн

сонгуульд өрсөлдсөн Энрике Каприлес жагсаалыг удирдаж, түүний төрийн албанд ажиллах эрхийг 15 жилээр хассаныг эрс шүүмжлэв. Ерөнхийлөгч Николас Мадурогийн социалист Засгийн газрын зүгээс сөрөг хүчнийг дарах оролдлогын хүрээнд ийм шийдвэр гаргасан аж. Каприлес хэлсэн үгэндээ тендерийн будлиан болон Британийн Засгийн газраас хууль бус хандив авсан зэрэг хэргүүдийг сөхөн ярьжээ.

Олон мянган хүн гудамжинд гарсны зарим нь “Дарангуйлагч засаглалд үгүй гэж хэлбэ”, Каприлесийг Ерөнхийлөгчөөр сонгохын төлөө” гэсэн уриа

лоозон барьжээ. Хууль тогтоох байгууллагыг сөрөг хүчин хяналтдаа авсан үед Венесуэлийн Засгийн газар өөрийн талын шүүгчдээр дамжуулан эрх мэдлээ чангатгахыг эрмэлзэж байгаа юм. Энэ байдал эсэргүүцлийн хөдөлгөөнийг улам дэврээж, аюулаас хамгаалах хүчин болон жагсагчдын хооронд мөргөлдөөн үүсгэлээ. Уг явдлын үеэр нэг хүн амь үрэгдэж, зуу гаруй хүн шархадсаныг хүний эрхийн бүлэг мэдээлжээ.

Каракас хотын 22 нстай оюутан Рафаэль Ромеро “Би энэ бүхнийг төгсгөл болгож, эрх чөлөөт Венесуэлийг сэргээхийн

төлөө жагсаалд ирсэн. Бид айдсаа гэж, гудамжинд гаран тэмцэх ёстой. Каприлест өгсөн цохилт биднийг зогсоохгүй. Харин ч бидний тэмцлийг эрчимжүүлэх шалтгаан болно” хэмээн ярилаа. Өмнөх жагсаалын үеэр цагдаа нар нийслэлийн том гудамжуудыг хуягт машинаар хааж, нулимс асгаруулагч хий ашиглан жагсагчдыг тараахыг оролдож байсан юм. Түүнчлэн метроны станцуудыг хааж, хот руу орох гол замууд дээр пост гарган, орж ирэх машинуудыг шалгах арга хэмжээ авчээ. Жагсагчдын зарим нь парламентын бүрэн эрхийг цуцлахыг оролдсон дээд

шүүхийн байрыг дайрсан байна. Бямба гарагт цагдаагийнхан жагсагчидтай мөргөлдөх үед биднийг зогсоохгүй. Харин ч бидний тэмцлийг эрчимжүүлэх шалтгаан болно” хэмээн ярилаа. Өмнөх жагсаалын үеэр цагдаа нар нийслэлийн том гудамжуудыг хуягт машинаар хааж, нулимс асгаруулагч хий ашиглан жагсагчдыг тараахыг оролдож байсан юм. Түүнчлэн метроны станцуудыг хааж, хот руу орох гол замууд дээр пост гарган, орж ирэх машинуудыг шалгах арга хэмжээ авчээ. Жагсагчдын зарим нь парламентын бүрэн эрхийг цуцлахыг оролдсон дээд

уялдаагаа сайжруулахын сацуу нэр хүндээ алдсан Ерөнхийлөгч Мадурод дарамт шахалт үзүүлж байгаа бол Засгийн газар тэднийг хүчирхийллийг гааруулаа хэмээн буруутгав. Венесуэлийн нөлөө бүхий дэд Ерөнхийлөгч Тарек Айссами жагсаалыг хууль бус, үндсэн хуулийн эсрэг гэж нэрлэсэн байна. 2012 оны сонгуульд Хорго Чавест, 2013 онд Мадурод цөөн хувиар ялагдсан Каприлесийг төрийн албанд ажиллахыг хориглосныг ажиглагчид 14 жил хоригдохоор шийтгэгдсэн Леопольдо Лопесийн хэрэгтэй адилтган үзэж байгаа юм.



Эдийн засаг

ИНФЛЯЦИ

Төгрөгийн ханш инфляцийг тодорхойлно

Богоино хугацаанд инфляциас айх шалтгаан алга

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Мөнгөний бодлогын зорилт бас сорилт нь болж байдаг инфляцийн төлөв байдлын тайлантай танилцъя. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн нэг бол инфляци. Тиймээс уг тайланг улирал тутам Монголбанк гаргаж, инфляцийн дунд хугацааны “ирээдүй”-г зураглаж ирсэн. Инфляцийг онилсон мөнгөний бодлогын хүрээнд төв банк олон нийтэд тайлангийн үр дүнгээ хуваалцлаа. Эдийн засгийн “эрүүл мэнд”-ийг тодорхойлдог инфляци энэ онд ялимгүй өсөхөөр байна. Өсөлт энэ оноор дуусахгүй бөгөөд ирэх онд ч үргэлжлэх нь.

Инфляци хэдий өсөх ч мөнгөний бодлогын зорилтот түвшнээс бага байх төлөвтэй байна. Мөнгөний бодлогын үндсэн чиглэлд инфляцийн түвшинг найман хувиар тодорхойлсон. Үүнийг хэвийн гэж ойлгож болох юм. Өөрөөр хэлбэл, инфляциас айх шалтгаан алга. Эдийн засгийн хүлээлт бага зэрэг сайжирсангай холбоотойгоор инфляцийн таамаглал өмнөх төсөөллөөс ялимгүй нэмэгдсэн байна. Энэ нь хямрал холдож, өсөлт дохиолж байгаа тэмдэг.

Эдийн засгийн өсөлт цаашид эрчимжих хандлага эерэг байгаа нь хүнсний бус инфляцийг энэ онд өсгөхөөр байна. Үүнийг инфляцийн сул тал гэж оношилж болох юм. Гэхдээ төгрөгийн ханш



Б.Ганбаяр / ЗГМ ©

өмнөх жилтэй харьцуулахад суларсан нь инфляцийн өсөлтөд ийнхүү нөлөөлж байна. Хэрэв төгрөгийн ханш тогтвортой байсан бол инфляцийн өсөлтөд ханшийн дарамт нөлөөлөхгүй байлаа. Манай улс үйлдвэрлэгч бус хэрэглэгч орны статустай байгаа нь төгрөг ам.доллар болон юанийн өмнө хүчгүйдэхэд хүргэж байгаа нь энэ.

Инфляцийн өсөлтөд махны үнэ жин дарж ирсэн. Тэгвэл өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний 30 орчим хувийг бүрдүүлдэг махны үнэ энэ оны эхний хагаст өсөх бол оны сүүлийн хагаст улирлын онцлогоо дагаад буурах нь. Үүнийг хувьд өмнөх жилтэй ойролцоо

Махны үнэ оны сүүлийн хагаст улирлын онцлогоо даган буурна

байхаар байна. Харин дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлт, төгрөгийн ханшийн уналтын дам нөлөөгөөр махнаас бусад хүнсний бүтээгдэхүүний үнэ ялимгүй өсөхөөр байгааг дуулгая. Ханшийн зөрүү та бидний худалдан авалтыг үнийн өсөлт болж хязгаарлах нь.

Азийн хөгжлийн банкны “Азийн хөгжлийн төлөв” тайланд

манай улсын инфляци ирэх хоёр жилд тодорхой хэмжээгээр өсөхөөр байгааг анхааруулсан. Тодруулбал, инфляци энэ онд 3.5, ирэх жилд 9.3 хувь хүртэл өсөхөөр байна. Онцгой албан татвар нэмэгдэхээр байгаа нь шатахууны үнэ өсөх, энэ нь өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үндэс дарамт болно гэжээ. Үүнийг “Инфляцийн төлөв байдлын тайлан”-д мөн өгүүлсэн. Улсын хэмжээнд инфляцийн түвшин 2.1 хувьтай тэнцэж буй.

Азийн хөгжлийн банкны зүгээс инфляцийн өсөлтийг тоон үзүүлэлтээр тодорхойлсон бол Монголбанк инфляцийн өсөлт зорилтот түвшнээс доогуур байна гэж таамаглаж байна. Инфляцийн задаргааг сүүлийн нэг жилийн хугацаанд авч үзвэл, өсөлтөд хамгийн ихээр нөлөөлсөн нь валютын ханшийн зөрүү. Өөрөөр хэлбэл, ам.доллартай харьцах төгрөгийн ханш тогтворгүй байх тусам инфляци өсөлтийн зүг заах нь. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» АРИЛЖАА

14.93

Хувь. Монголын хөрөнгийн биржийн индекс баасан гарагт 841.28 нэгж болж, 1.23 хувиар буурав. Энэ өдөр 21 компанийн хувьцааны ханшид өөрчлөлт орсон байна. Арилжаанд оролцсон компаниудаас “Монгол савхи” компанийн хувьцааны ханш хамгийн өндөр буюу 14.93 хувиар өссөн бол “Авто импекс”-ийнх 14.53 хувиар буурчээ.

» УУЛ УУРХАЙ

5.1

Тэрбум тонн. Тавантолгойн орд 7.4 тэрбум тонн нүүрсний нөөцтэй. Үүний 5.1 тэрбум тонн нь коксжих шинж чанартай нүүрс.

» ТӨСӨВ

2.1

Хувь. Нүүрсний экспорт нэмэгдсэнээр энэ онд урсгал дансны алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 2.1 хувьд хүрч буурахаар байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2428.75
Евро	2583.46
Япон иен	21.96
ОХУ рубль	42.69
БНХАУ юань	352.06
БНСУ вон	2.14

ХАНШ

Голлох валютуудын ханш суларлаа

Г.Байгал
ЗГМ

Төв банкнаас зарласан ам.долларын албан ханш өнгөрсөн долоо хоногт нийт 14.6 нэгжээр хямдарчээ. Баасан гарагийн байдлаар төгрөгтэй харьцах “ногоон”-ы ханш 2428.75 төгрөгтэй тэнцэж байгааг Монголбанкнаас мэдээлсэн. Харин дөрөвдүгээр сар гарсаар төгрөгийн ханш 18 нэгжээр чангарч, ам.долларын ханш төдий хэмжээгээр суларчээ. Сүүлийн сар гаруйн хугацаанд алгуур чангарч буй төгрөгийн ханш одоогоор 2016 оны арваннэгдүгээр сарын түвшинтэй дүйж байна.

Арилжааны банкууд өнгөрсөн пүрэв гарагт 2427 төгрөгийн ханшаар дөрвөн сая ам.доллар худалдан авах, 2437.13 төгрөгийн ханшаар 32.4 сая ам.доллар худалдах захиалга Монголбанкинд хүргүүлсэн байна. Харин төв банк 29.9 сая ам.долларыг нэг бүрийг нь 2437.51 төгрөгөөр худалдан авчээ. Мөн арилжааны банкууд 3.5 сая ам.доллар худалдан авах төгрөгийн своп хэлцэл байгуулах санал ирүүлсэн боловч Монголбанк саналыг биелүүлсэнгүй.

Хоёрдугаар сарын 19-нд Сангийн яам, Монголбанк Олон улсын валютын сангай хамтрах болсноо зарласан. Энэ мэдэгдлээс нэг өдрийн дараа Монголбанкны төгрөгтэй харьцах ам.долларын

ханш гурав орчим төгрөгөөр суларсан юм. Үүнээс хойш төгрөг тасралтгүй хүчээ авч, “ногоон” завсаргүй суларсаар 60 орчим төгрөгөөр суларчихаад байна. Мөн төгрөгтэй харьцах бусад валютын ханш ч буураад байгаа юм. Тухайлбал, төгрөгтэй харьцах евро, юань зэрэг валютын ханш өнгөрсөн сарын дундуур үл ялиг чангарсангай удалгүй уруудав. Еврогийн ханш өнгөрсөн сарын 27-ноос эхлэн тасралтгүй уруудаж, нийт 66 төгрөгөөр буураад байна. Арав гаруй хоногийн өмнө 2671 төгрөгтэй тэнцэж байсан еврогийн ханш баасан гарагийн байдлаар 2583 нэгжид хүрлээ. Мөн юанийн ханш өнгөрсөн долоо хоногоос уруудаж, нийт зургаан төгрөгөөр суларчээ. [ЗГМ]

МЭДЭГДЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД, МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.ЭРДЭНЭБАТ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭД,

Монголын бизнесийн зөвлөл (МБЗ) нь тэгш шударга, тогтвортой, ил тод бизнесийн орчинг тууштай дэмжин ажилладаг.

Юуны түрүүнд, бид Олон улсын валютын сангийн (ОУВС) Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг УИХ-аар баталж, улмаар Монгол Улсын Засгийн газар түүнийг хэрэгжүүлэх зүйтэй хэмээн үзэж байна. Олон улсын зах зээл болон зээлийн агентлагууд ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжиж Монгол Улсын эдийн засаг болон эрсдэлийн төлөв байдал тогтворжино гэсэн эерэг хүлээлттэй байгаа. Хэрэв тус хөтөлбөр хэрэгжихээрхгүй болох тохиолдолд улс төр, хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлэх сөрөг үр дагаврыг дагуулах нь дамжиггүй юм. Түүнчлэн УИХ-аар хэлэлцэж буй “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-д тусгасан татварын өөрчлөлтүүд нь Монголын бизнесийн зөвлөлийн гишүүн байгууллагуудыг түгшээж байна. Тиймээс энэхүү мэдэгдлээр бид дараах саналыг хүргүүлж байна. Үүнд.

1. Нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэх нь хамгийн бага орлоготой иргэдэд хамгийн хүндээр тусна. Түүнчлэн жижиг, дунд үйлдвэрлэл, аж ахуйн нэгжүүдэд илүү дарамт учруулах урвуу нөлөөлөлтэй.
2. Хувь хүний орлогын хувь хэмжээнээс хамааран Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) хэсэг бүлэг хүмүүст хоёр дахин хүртэлх хэмжээнд нэмэгдэж байгаа нь шударга бус явдал юм. Хэрэв ХХОАТ нэмэх шийдвэрт хүрвэл нийт иргэдэд ижил тэгш үйлчлэх зарчмыг баримтлах хэрэгтэй.
3. Хувь хүн, хувийн хэвшилд эргэлдэж буй мөнгөн дүнг татвар нэмэгдүүлэх замаар бууруулах нь эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлөх болно.
4. Татварын өнөөгийн хувь, хэмжээг өсгөхөөс илүүтэй татварын суурь баазыг нэмэгдүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах боломжит бусад арга замуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэдгийг Монголын бизнесийн зөвлөл онцгойлон илэрхийлж байна.

Жишээлбэл.

1. Эдийн засгийн өршөөлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнд шинжилгээ хийж ил болсон орлогын эх үүсвэр, хөрөнгийг бүртгэх.
2. Оффшорт төвлөрсөн хөрөнгийг эдийн засгийн аргаар Монгол Улсын эдийн засагт эргүүлэн татах.
3. Тэтгэврийн санг хэсэгчлэн хувьчлах буюу хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх. Ингэснээр тэтгэврийн санд учрах алдагдлыг бууруулж, иргэдэд очих тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх боломж нээгдэнэ.
4. Шударга өрсөлдөөнийг чөдөрлөж буй төрөөс зохицуулсан татаас, хөнгөлөлтийг зогсоох.
5. Зах зээлд “үнийн тааз” үүсгэж өрсөлдөөний шударга бус орчинг үүсгэж, алдагдалтай ажиллаж буй төрийн өмчит компаниудыг хувьчлах.
6. Төсвийн зарлагыг бууруулж, төрийн албан хаагчдын орон тоог багасгах.

Монголын бизнесийн зөвлөл нь гишүүн байгууллага болон бизнесийн салбарын бүх оролцогч талуудыг Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, тогтоомжийг дагаж мөрдөхийг тууштай уриалж байна. Мөн татвараас зайлсхийхийг бид дэмжихгүй. МБЗ-ийн баримтлалд тэргүүний чиглэл бол УИХ, Монгол Улсын Засгийн газартай тогтмол харилцаа холбоог үүсгэж, өрнүүлэх замаар бизнес эрхлэгчдийн дуу хоолойг хүргэж, хүндрэл бэрхшээлээ илэрхийлж, хамтын шийдэлд хүрэх явдал юм.

Иймд бүх оролцогч талуудад харилцан үр ашигтай нөхцөл, байдлыг бий болгох, Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хурдасгах арга хэмжээг судлах, боловсруулах, мөн зөв шалгалтыг хийхэд УИХ-ын эрхэм гишүүд, Монгол Улсын Засгийн газрыг хувийн хэвшилд-бондтой хамтран ажиллахыг урьж байна.

Монголын бизнесийн зөвлөл
2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр
Улаанбаатар хот

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо . 2017.04.10

Тендер шалгаруулалтын нэр. Ус сувгийн удирдах газарт эргэлтийн насос нийлүүлэгчийг сонгох шалгаруулах. Тендер шалгаруулалтын дугаар. УСУГТ-ХА-2017-03-44

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос эргэлтийн насос нийлүүлэгчийг сонгох шалгаруулах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 /тави мянган/ төгрөгийг Ус сувгийн удирдах газрын Хас банк 5000075928 дансанд тушааж худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерг оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүн.

- Сүүлийн 2 жил 2015, 2016 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- Сүүлийн 2 жил 2015, 2016 онд ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.
- Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил тус бүр 300,000,000 /гурван зуун сая/ төгрөгөөс дээш байх.
- Тендерийн хамт 1,600,000 /нэг сая зургаан зуун мянган/ төгрөгийн баталгаа ирүүлнэ.
- Хүчинтэй байх хугацаа. 2017 оны 07 дугаар сарын 22-ний өдрийг дуусгал.

Тендерийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 09 цаг 30 минутаас 10 цаг 00 минут-ын хооронд доорх хаягаар тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 30 минут-аас нээнэ. Гадаадын этгээд оролцох эрхгүй. Дотоодын давуу эрх тооцоггүй. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токмогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас. 70157019-223

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо . 2017.04.10

Тендер шалгаруулалтын нэр. Ус сувгийн удирдах газарт цахилгаан үүсгүүр нийлүүлэгчийг сонгох шалгаруулах. Тендер шалгаруулалтын дугаар. УСУГТ-ХА-2017-03-67

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос цахилгаан үүсгүүр нийлүүлэгчийг сонгох шалгаруулах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 /тави мянган/ төгрөгийг Ус сувгийн удирдах газрын Хас банк 5000075928 дансанд тушааж худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерг оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүн.

- Сүүлийн 2 жил 2015, 2016 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- Сүүлийн 2 жил 2015, 2016 онд ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.
- Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил тус бүр 300,000,000 /гурван зуун сая/ төгрөгөөс дээш байх.
- Тендерийн хамт 2,000,000 /хоёр сая/ төгрөгийн баталгаа ирүүлнэ.
- Хүчинтэй байх хугацаа. 2017 оны 07 дугаар сарын 23-ний өдрийг дуусгал.

Тендерийг 2017 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн 09 цаг 30 минутаас 10 цаг 00 минут-ын хооронд доорх хаягаар тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн 10 цаг 30 минут-аас нээнэ. Гадаадын этгээд оролцох эрхгүй. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токмогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас. 70157019-223

Эдийн засаг

БАЙР СУУРЬ

Б.Лхагважав: Төрийн тансаглалын төлөө татвар төлдөггүй

Төрийн тансаглалын төлөө татвар төлдөггүй

Б.Мөнх
ЗГМ

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч Б.Лхагважавтай ярилцлаа.

-Төрийн өмчит компаниудад сайн засаглал үгүйлэгдэж байна. Компанийн засаглал тааруу байгаагаас алдагдал нь дорвитой буурахгүй байсаар одий хүрлээ. Энэ байдлыг яаж засах вэ?

-Хэрвээ эдийн засгийн шинэ нөхцөлд зохицож засаглал, менежментээ сайжруулахгүй байвал хөрөнгө оруулагүй Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагаа сонгож чадаагүй компаниуд зах зээлд орон зайгаа тавьж өгнө. Төрийн өмчит компаниуд улс төрийн дэмжлэгээр монополь байдлаа хамгаалж болох ч энэ байдал нь удаан хугацаанд үргэлжлэх боломжгүй. Тухайлбал, концессийн гэрээнд оролцож байгаа компаниудыг хувьцаат компани болгох хэрэгтэй. Өрсөлдөөнийг шударга байлгах нь хамгийн чухал. Нөхцөл байдал хаалттай, ил тод бус байдал цаашид үргэлжилсээр байвал татвар төлөгч нар ирээдүйд маш том хохирол амсана. Тиймээс шударга өрсөлдөөнийг бий болгоход нээлттэй байдал чухал.

-Ялангуяа сүүлийн жилүүдэд төр хувийн хэвшилтэйгээ өрсөлдөх нь даамжирсан. Өрсөлдөөний шударга бус байдал ч хавтгайрсан тал бий. Ийм үед ямар менежмент нэвт-



Б.Ганбаяр / ЗГМ©

рүүлэх нь эдийн засгийн хувьд ач холбогдол нь өндөр байх вэ?

-Төрийн өмчийн компаниуд хувийн компанитай өрсөлдөхөд эрх мэдлээрээ давуу ч эцэстээ ялагдал хүлээдэг. Сүүлийн дөрвөн удаагийн эдийн засгийн хямралын дараа манай төрийн өмчит компаниуд үхдэггүй, сэхдэггүй хэвээр байсаар л байна. Энэ хооронд хувийн компаниуд бага багаар өссөөр 1000, 2000 хүнтэй томоохон аж ахуйн нэгж болж, илүү томоор тоглох орон зайгаа хайж эхэллээ. Төрийн өмчит улсын үйлдвэрийн газруудыг маш хурдан хугацаанд хувьцаат компани болгох шаардлагатай. Гэхдээ хувьчлалын өмнөх алдааг давтахгүйгээр хөдөлмөрийн хамт олныг нь авч үлдэх замаар үүнийг хийх нь зөв.

Төр зардлаа танаж чадвал Онцгой албан татварыг заавал нэмэх шаардлагатай.

чухал. Гэтэл төсвийн тодотголдо зардлаа нэмж оруулж ирсэн. Энэ нь өнөөгийн нөхцөл байдалтай нийцэхгүй. Тиймээс татвар төлөгчид Засгийн газрын татвар нэмэх тухай саналыг эсэргүүцэж байгаа. Төр одоогийн данхар бүтцээ хумих шаардлагатай. Цомхон бүтэцтэй, чадварлаг төр хэрэгтэй байна. Татвар төлөгч нар нийтийн сайн сайхны төлөө татвар төлдөг. Түүнээс төрийн тансаглалын төлөө татвар төлдөггүй. Төсвийн зардлыг 2017 оны баталсан хэмжээнээс огт нэмэгдүүлэх байх шаардлага манай мэдэгдэлд бий. Учир нь, энэ оны нэгдсэн төсвийн тодотгоор нийт зарлага болон цэвэр зээлийг баталсан түвшнээс нь 220.7 тэрбум төгрөгөөр нэмсэн байна.

-Танай гаргасан мэдэгдэлд төр албан хаагчаа багасгах талаар дурдсан байсан. Энэ нь хэмнэлт болж чадах уу?

-Төрийн захиргааны албан хаагчдын тоог 20, үйлчилгээний албан хаагчдын тоог 10 хувиар бууруулах санал хүргүүлсэн. Төрийн албан хаагчдын тоо 2012 оноос хойш ойролцоогоор 15 хувь буюу 24 мянгаар тасралтгүй өссөн. Мөн төрийн албан хаагчдын шаардлагагүй зардал, нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмжийг зогсоох хэрэгтэй. Энэ байдлаар хэмнэлт хийж болно.

-Та бүхний шаардлага ОУВС-гийн шаардлагатай хэр нийцэж байгаа вэ?

-Олон улсын валютын сангийн үндсэн шаардлагатай манай танхимаас гаргасан мэдэгдэл уялдаж байгаа. Төрийн буруу менежментийн алдааг засахгүй бол татвар төлөгчид улам хүнд байдал орж мэдэхээр байна. Төрийн зардлыг татвар төлөгчид төлж дийлэхгүй нь. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих

тухай хууль, НӨАТ-ын тухай хууль хэрэгжиж эхэлснээр 2016 оны төсвийн татварын орлого төлөвлөж байснаас 487.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 2015 онтой харьцуулахад өнгөрсөн оны гүйцэтгэлээр 70 гаруй тэрбум төгрөгөөр өссөн. Сүүлийн 20 жилд анх удаа татварын орлого бүх төрлөөр биеллээ. Он гарсаар эхний гурван сард татварын орлого 30 хувиа давж биелсэн. Татварын орлого давж биелээд байхад татвар нэмнэ гэдэг хүлээж авах боломжгүй шийдэл. Татварын орлого тасарсан бол үүнийг бид ойлгож хүлээж авна. Эдийн засаг хүндрэлтэй байгаа хэдий ч төсөвт төвлөрөх татварын орлого давж байна. Үүнийг олзуурах хэрэгтэй.

Цомхон бүтэцтэй чадварлаг хүний нөөцтэй төр хэрэгтэй байна

-Төсвөөс татаас авдаг, алдагдал өндөртэй төрийн өмчит аж нэгжүүдийг хувьчлах, татан буулгах асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байгаа. Энэ талаар таны байр суурийг сонирхоё?

-Төрийн өмчит 90 гаруй, орон нутгийн өмчит 200 орчим компани бий. Энэ нь манай эдийн засгийн зовлон болчихоод байна. Эдгээр компани, аж ахуйн нэгжийг улс төрөөс хол байлгах хэрэгтэй. Улс төрийн нөлөөнөөс хол байх тусам бизнесийн үр ашиг нь дээшилж, эдийн засгийн эрүүл горимоор буюу бизнесийн зарчмаар ажиллаж эхэлнэ.

-“Эрдэнэт” үйлдвэрийн Төлөөлөн удирдах зөвлөлийг төрөөс 100 хувь бүрдүүллээ. Үүнийг зөв шийдвэр байсан гэж үзэж болох уу?

-Зөв шийдвэр байсан гэж хэлэх боломжгүй. Төрийн оролцоо “Эрдэнэт” үйлдвэрт аль болох бага байх хэрэгтэй. “Эрдэнэт” өмнө нь хязгаарлагдмал хариуцлагатай компани байсан. Харин сая нэг шат доошуулчихлаа. “Эрдэнэт”-ийг нэг шат ахиулж, улмаар хувьцаат компани болгох нь зөв шийдвэр. Үүнийг дагаад компанийн засаглал болон бизнесийн үйл ажиллагаанд нь дэвшил гарна. Тиймээс цаг алдалгүй хувьцаат компани болох нь илүү ирээдүйд ашигтай.

-Онцгой албан татварыг нэмэгдүүлэхгүй байх саналыг танай зүгээс гаргасан. Хэрэв нэмлээ гэхэд эдийн засагт яаж нөлөөлөх вэ?

-Татварын шинэчлэл эхэлсэн. Энэ хүрээнд НӨАТ-ын тусламжтайгаар орлого болгоныг бүртгэдэг боллоо. Бид нийт зах зээлийнхээ 60 хувиас татвар авч чадахгүй байсан. Одоо далд эдийн засгаасаа аваад эхэлж байгаа эхний эерэг үзэгдэл юм. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль үүнд онцгой үүрэг гүйцэтгэсэн. Төр зардлаа танаж чадвал Онцгой албан татварыг заавал нэмэх шаардлагатай. Татвар нэмлээ гэхэд иргэдэд үнийн өсөлт болж дарамт нь ирнэ. Шударга өрсөлдөх боломжийг хааж буй татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг үзүүлэхгүй байх талаар бид мөн хөндсөн. Нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэхгүй байх хэрэгтэй. Цаг үе нь одоо лав биш. Үүнийг харгалзаж, ухаалаг эрүүл горимоор гаргах гэж найдаж байна. [ЗГМ]

Ам.долларын спот индекс 0.3 хувиар өслөө



Ам.долларын спот индекс сүүлийн нэг сард (нэгжээр)

АНУ-ын ажилгүйдлийн түвшин 10 жилийн доод цэгт хүрлээ. Тус улсын ажилгүйдлийн түвшин өнгөрсөн сард 0.2 хувиар буурч, 4.5 хувьтай тэнцсэнийг албаныхан нь мэдээлэв. Америкийн хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлт сайжирсан нь тус улсын эдийн засаг сэргэж буйн баталгаа. Үүнээс үүдэн мөнгө болоод санхүүгийн

үзүүлэлтүүд нь дээшиллээ. Сар орчмын хугацаанд суларсан ам.долларын ханш сэргэв. “Bloomberg”-ээс тооцдог ам.долларын спот индекс л гэхэд 0.3 хувиар өсөж, гурван долоо хоногийн дээд цэгт хүрсэн байна. Тухайлбал, евротой харьцах ам.долларын ханш 0.5 хувиар чангарч, дөрвөн долоо хоногийн дээд цэгт тулжээ. [ЗГМ]

Засгийн Газрын МЭДЭЭ

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	60.01	▼ -1.1%	4/7/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.034	▼ -5.56%	4/7/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	27.625	▲ +4.74%	4/8/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.025	▼ -7.41%	4/7/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	4/7/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.7	▲ +3.35%	4/8/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.07	▲ -1.69%	4/8/2017
SOUTHGObI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.365	▼ -3.95%	4/7/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.225	▲ +2.27%	4/7/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.7	▲ +1.45%	4/8/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1254.53	▼ -0.46%	4/8/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	962.6	▲ +0.39%	4/8/2017
МӨНГӨ	SIA	унци	18.151	▼ -0.52%	4/8/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	264.7	▼ -0.41%	4/8/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	76.91	▼ -0.65%	4/7/2017
WTI ТОС	CLA	баррель	52.24	▲ +1.04%	4/8/2017
БРЕНТ	COA	баррель	55.24	▲ +0.67%	4/8/2017
БЕНЗИН	XBA		174.62	▲ +0.96%	4/8/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.261	▼ -2.1%	4/8/2017
НҮҮРС (NYMEX)	OZA	тонн	336.55	▲ +0.21%	4/7/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	87.1	▲ +0.17%	4/8/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.167	▲ +1.82%	4/8/2017
БУДАА	RRA	центнер	10.23	▲ +0.2%	4/8/2017
БУУДАЙ	WA	бушель	424	▲ +0.18%	4/8/2017
КАКАО	CCA	тонн	2007	▼ -3.83%	4/8/2017
КОФЕ	KCA	фунт	1.400	▲ +1.74%	4/8/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

Тэнцвэртэй мэдээллийг Танд

WORLD
FT
The New York Times

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	335.39	▼ -1.53%	4/7/2017
ГОВЬ ХК	GOV	12430	▲ 1.55%	4/7/2017
МИК ХОЛДИНГ ХК	MIK	10360	▼ -9.91%	4/7/2017
МАХ ИМПЕКС ХК	MMX	2443	▲ 0.49%	4/7/2017
СҮҮ ХК	SUU	129.58	▼ -1.88%	4/7/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	23000	▲ 14.31%	4/7/2017
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	2426	▲ 2.84%	4/7/2017
БАГАНУУР ХК	BAN	1650	▼ -10.76%	4/7/2017
УБ-БУК ХК	BUK	360	◀▶ 0%	4/7/2017
АРИГ ГАЛ ХК	EER	2350	▼ -3.89%	4/7/2017
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК	ETR	99	◀▶ 0%	4/7/2017
ГЕРМЕС ЦЕНТР ХК	HRM	142	▼ -10.69%	4/7/2017
ХАСУ-МАНДАЛ ХК	HSR	5160	◀▶ 0%	4/7/2017
ЖЕНКО ТҮР БҮРО ХК	JTB	55.05	▼ -1.7%	4/7/2017
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	522.7	▲ 0.52%	4/7/2017
МАТЕРИАЛИМПЕКС ХК	MIE	8500	◀▶ 0%	4/7/2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	390	▼ -1.18%	4/7/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5877.812	-1.14	▼ -0.02%	4/8/2017
DAX INDEX	DAX	12225.06	-5.83	▼ -0.05%	4/7/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15667.13	-30.05	▼ -0.19%	4/8/2017
S&P ASX 200	AS51	5862.469	+6.18	▲ +0.11%	4/7/2017
S&P 500	INX	2355.54	-1.95	▼ -0.08%	4/8/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3286.616	+5.61	▲ +0.17%	4/7/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	20656.1	-6.85	▼ -0.03%	4/8/2017
TOP 20	MSETOP	12974.3	+133.39	▲ +1.04%	4/7/2017
FTSE 100	UKX	7349.37	+46.17	▲ +0.63%	4/8/2017
HANG SENG	HSI	24267.3	-6.42	▼ -0.03%	4/7/2017
NIKKEI 225	NKY	18664.63	+67.57	▲ +0.36%	4/7/2017